

МОНГОЛ-ЯПОНЫ БИЗНЕС ФОРУМД ЗОРИУЛСАН
ТУСГАЙ ДУГААР

2021 оны 5 дугаар сар

INVEST IN MONGOLIA

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРААС ЭРХЛЭН ГАРГАВ
ДУГААР 04

АГУУЛГА

ЯПОН УЛСЫН ШУУД ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ, ЯПОН УЛС
ХООРОНДЫН ХАРИЛЦАА

ТӨСӨЛ ЧАДАВХИЖУУЛАХ
ХӨТӨЛБӨР

ТӨСЛҮҮДИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА

ВЕБИНАР БОЛОН
АРГА ХЭМЖЭЭ

ОНЦЛОХ САЛБАР ХӨДӨӨ
АЖ АХУЙ

АМЖИЛТЫН ТҮҮХ

“АЛСЫН ХАРАА - 2050” МОНГОЛ
УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО БА ЯПОН
УЛСТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

МОНГОЛ УЛСЫН СЭРГЭЭГДЭХ
ЭРЧИМ ХҮЧНИЙ ИРЭЭДҮЙ

ЭРХЭМ УНШИГЧ ТАНД ЭНЭ ӨДРИЙН МЭНД ХҮРГЭЭ

Монгол Улсад бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе. Мөн Танд зориулж эрхлэн гаргадаг "Invest in Mongolia" эмхэтгэлийн 5 дугаар сарын дугаарыг хүргэж байгаадаа таатай байна.

Монгол, Япон хоёр улсын хооронд 1972 оны оны хоёрдугаар сарын 24-ны өдөр анх дипломат харилцааг тогтоосон билээ. Уг өдрөөс эхлэн манай улсад буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, хандив, үйлдвэр, сургууль, цэцэрлэг, шинэ нисэх онгоцны буудал, зам, гүүр гэх мэт бүхий л салбарт тусалж дэмжин оролцож байна. Өөрөөр хэлбэл бидний үр хүүхэд, ирээдүй хойч минь энэхүү үр дүн, ашиг шимийг хүртэж байгаа нь та бүхний сэтгэл шингэсэн бүтээн байгуулалтад оршиж байна. Монголын ард түмэнд тусалдаг Япон Улсад БАЯРЛАЛАА.

Бид Монгол улсын Ерөнхий сайдын удирдлага дор бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах цогц шинэчлэлийг эхлүүлээд байгаа билээ. Хөрөнгө оруулалтын цогц шинэчлэлийн хүрээнд хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах, цар тахлын үеэр хөрөнгө оруулагчдад зориулсан цахимжилт, төрийн болон бусад байгууллагуудтай хамтарсан хөрөнгө оруулагчдад зориулсан үйлчилгээний хялбаршуулалт зэрэг ажлуудыг багтаасан болно.

Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалт татах, дэмжих чиглэлээр бодлогын зөвлөмж гаргах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий Хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл болон Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулахдаа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх хуулийн этгээдийн төлөөлөөр тухайн асуудлыг хэлэлцүүлж, санал авч, зөвшилцөл хийх, бизнесийн орчинд тулгарч буй асуудлыг хамтран шийдвэрлэх зорилго бүхий Бизнесийн зөвлөлийг байгуулах гэж байна. Эдгээр зөвлөл нь хариуцсан асуудлын хүрээнд зөвлөмж гаргаж, Ерөнхий сайд болон Засгийн газарт хүргэх чиг үүрэгтэй.

Мөн Үндэсний Хөгжлийн Газар нь 5 дугаар сард Япон улстай, 6 дугаар сард Бүгд Найрамдах Солонгос улстай хамтын ажиллагааг эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбарт өргөжүүлэх, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд Монгол Улсын хөрөнгө оруулалт, бизнесийн орчны талаарх шинэ мэдээллийг хүргэх зорилготойгоор Хөрөнгө оруулалтын форумуудыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгааг уламжлахдаа таатай байна.

Энэхүү товхимолтой холбоотой санал хүсэлтийг манай газрын info@nda.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Үндэсний хөгжлийн газрын хөрөнгө оруулалтын бодлого, олон талт харилцаа хариуцсан дэд дарга

Б. БУЛГАНЧИМЭГ

ЯПОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТӨСЛӨӨ ТАНИЛЦУУЛНА

"INVEST IN TOKYO 2021" МОНГОЛ ЯПОНЫ БИЗНЕС ФОРУМЫН
ТАНИЛЦУУЛГА

Монгол, Японы худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Үндэсний хөгжлийн газар, Японы Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын байгууллага /JETRO/, Монгол Улсаас Япон улсад суугаа ЭСЯ, Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC), Ирбис Венчурс компанитай хамтран "Invest in Mongolia - Tokyo 2021" Монгол, Японы бизнес форумыг цахимаар зохион байгуулах гэж байна. Мөн дэмжигч байгууллагаар Монгол Улсын Гадаад харилцааны яам, Японы Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам /METI/ нар хамтран ажиллаж байна.

Форумын хүрээнд Японы хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд Монгол Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах шинэчлэлийн төлөвлөгөөг танилцуулахаас гадна Монгол Улсад хөрөнгө оруулж, бизнес эрхэлж буй Японы хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн төлөөллүүд туршлагаасаа хуваалцана.

Үндэсний төсөл хэрэгжүүлэгч компаниудыг дэмжих зорилгоор Үндэсний хөгжлийн газар, Сингапур улсад төвтэй Ирбис Венчурс болон Жи-Эм-Жи Консалтинг компанитай хамтран "Төсөл чадавхижуулах хөтөлбөр"-ийг зохион байгуулж, шалгарсан төслүүдийг 1 сарын турш чадавхижуулсан бөгөөд эдгээр төслүүдийг форумын үеэр Япон улсын хөрөнгө оруулагчдад танилцуулна.

Өөрөөр хэлбэл, орчин үеийн хамгийн их анхаарал татаж буй бизнесийн салбарууд болох мэдээллийн технологи, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүч, технологийн салбарын төслүүдийг танилцуулна.

Арга хэмжээний болон төслүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг

www.japan.investmongolia.gov.mn

авна уу.

Зохион байгуулагч байгууллагууд:



INVEST IN MONGOLIA
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



EMBASSY OF MONGOLIA IN JAPAN



IFC International
Finance Corporation
WORLD BANK GROUP
Creating Markets, Creating Opportunities



Japan External Trade Organization

Дэмжигч байгууллагууд:



MINISTRY OF FOREIGN AFFAIRS
OF MONGOLIA



METI
Ministry of Economy, Trade and Industry

irbis ventures


МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Нийт газар нутгийн хэмжээ
1.564.116 км²

Нийт хүн ам
3.2 САЯ



Бичиг үсэг тайлагдалт
98.2%



Гадаад худалдаа
\$12.9 ТЭРБУМ



ДНБ
\$13.3 тэрбум



Экспортын түвшин
\$7.6 ТЭРБУМ



Ажиллах хүчний 65% нь
15-65 НАСНЫ ХҮМҮҮС



Импортын түвшин
\$5.3 ТЭРБУМ



Нийт пшхо /1990-2020/
\$29.6 ТЭРБУМ

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЗҮҮЛЭЛТ (ЗҮҮН АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГТ)

- Бизнес эрхлэхэд хялбар байдлын индекс **10-Т**
- Барилгын зөвшөөрөл авах **6-Т**
- Зээл авах **4-Т**
- Хөрөнгө оруулагчийн хамгаалал **6-Т**
- Татвар төлөлт **7-Т**
- Монгол Улсын зээлжих зэрэглэл (Moody's) **В3 ТОГТВОРТОЙ**

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХ БОЛОМЖУУД, ДАВУУ ТАЛУУД

ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН
ТУХАЙ МОНГОЛ УЛС, ЯПОН УЛС
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР
(JMEPA)

- Монголын талаас **5,700**
 - Японы талаас **9,300**
- / Төрлийн бараа бүтээгдэхүүнийг харилцан импортын гаалийн татвараас шууд болон үе шаттайгаар чөлөөлөх /

ЕВРОПЫН ХОЛБООНЫ
ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ
СИСТЕМ GSP+

7200 бараа бүтээгдэхүүнийг европын холбооны улсуудад гаалийн тарифын хөнгөлөлт

АНУ-ЫН ХӨНГӨЛӨЛТИЙН
ЕРӨНХИЙ СИСТЕМ
GSP +

АНУ-ын зах зээлд 3500 гаруй бүтээгдэхүүнд гаалийн татваргүй нэвтрэх нөхцөл

АЗИ НОМХОН ДАЛАЙН
ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР
/ Энэтхэг, Өмнөд Солонгос,
Шри Ланка, Лаос, Бангладеш,
БНХАУ /

Гишүүн улсын зах зээлд 10,667 төрлийн бараа бүтээгдэхүүний тариф бууруулах

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖУУД



- Хайгуулын тусгай зөвшөөрөл
- Шинэ боломжуудад хөрөнгө оруулалт хийх - зэс катод зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг
- Газрын ховор элементийг хайх, олборлох



- Мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх
- Органик бүтээгдэхүүн: чацаргана ба зөгийн бал
- Мах экспортолох
- Дотоодын хэрэглээний хүнсний ногоо тариалалт



- Азийг эрчим хүчээр хангах боломжтой нар, салхины шавхагдашгүй нөөцтэй.
- Монгол Улс нь дэлхийн сэргээгдэх эрчим хүчний нөөцийн гуравны нэгийг үүсгэх боломжтой улсын хувьд, Азийн эрчим хүчний супер сүлжээ болох боломжтой
- Монгол Улсад 2,600 гегаватт (гВт) нар, салхины эрчим хүчний эх үүсвэрийг суурилуулж ашиглах боломжтой. Энэ нь жилд 5,457 тераватт (тВт)-цаг байгальд ээлтэй цэвэр эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал гэсэн үг юм



- Монгол бол Ази, Европийг холбосон тээвэр, логистикийн зангилаа худалдааны найдвартай коридор юм. 45 хоног зарцуулах далайн замтай харьцуулахад хуурай газрын замаар 11 хоног зарцуулдаг.



- Монгол Улс технологийн компаниудад ашиглагдаагүй асар том боломжийг нээж өгч байна. Энд боловсролтой, авъяаслаг мэдээллийн технологийн ажилчдын асар их хөдөлмөрийн нөөц байдаг бөгөөд цалин хөлс нь бусад хөгжингүй орнуудтай өрсөлдөх чадвартай.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХУВЬД МОНГОЛ УЛС ТАНД:



ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ

- Гадаадын хөрөнгө оруулагчтай эрх тэгш хандах бодлого
- Таны бизнес цэцэглэн хөгжихөд зориулсан тогтворжуулалтын багц
- Эдийн засгийн чөлөөт бүсэд Татварын хөнгөлөлт чөлөөлөлт эхний 5 жил
- 60 + 40 хүртэлх жилийн хугацаатай газар ашиглах эрх
- Инновацлаг, бүтээлч гарааны бизнесүүдэд илүү боломжийг олгож ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шинэ бизнесээ турших sandbox аргыг санал болгож байна.



ДЭМЖЛЭГ, СУРТАЛЧИЛГАА

- Хөрөнгө оруулагчдад зориулсан нэгдсэн мэдээллийн хуудас www.investmongolia.gov.mn-д зочлох
- Хөрөнгө оруулагчдад зориулан англи, монгол хэл дээр сар тутам эрхлэн гаргадаг “Invest in Mongolia” цахим сэтгүүл
- Хөрөнгө оруулалт хийх бизнесийн төслүүдийг Pitchbook 2021-ээс
- Үндэсний бизнесүүдийг олон улсын зах зээлд сурталчлах, хөрөнгө оруулагчдад танилцуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”
- Удахгүй болох “Invest in Mongolia” Токио 2021, Сөүл 2021 арга хэмжээнүүдэд бүртгүүлэх
- Дараах манай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зочилж, шинэлэг мэдээлэл авч байгаарай
<https://www.facebook.com/ndagovMN>
<https://twitter.com/ndagovMN>



ЦАХИМЖСАН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

- www.investmongolia.gov.mn цахим хуудсанд хөрөнгө оруулагчдад зориулсан Ковид19 цэс
- Цар тахлын үед хөрөнгө оруулагчдад үзүүлэх бодлогын болон үйлчилгээг сайжруулах талаарх судалгаанд хамрагдана уу.
- Засгийн газрын 5 агентлагийн 62 төрлийн үйлчилгээг хөрөнгө оруулагчдад үзүүлдэг Нэг цэгийн үйлчилгээний төвөөр ороод гараарай.
- Виз сунгуулах талаарх мэдээлэл, лавлагааг www.invest-assist.gov.mn –ээс авна уу.
- Гомдлоо www.ipc.gov.mn -ээр шууд ирүүлнэ үү.



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХАМГААЛЛЫН МЕХАНИЗМ:

- Хөрөнгө оруулалттай холбоотой өргөдөл гомдлыг www.ipc.gov.mn эсвэл Ерөнхий сайдын удирдсан Хөрөнгө оруулалтын зөвлөлөөр дамжуулан шийдвэрлэдэг
- Шүүх үйлчилгээ нь олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжийн дагуу үүссэн маргааныг шийдвэрлэх боломжтой;
- Танд бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийхэд туслах чадварлаг, мэргэшсэн мэргэжилтнүүдтэй /home doctors/ ажлын алба нь Үндэсний хөгжлийн газарт ажилладаг.
- Үндэсний хөгжлийн газрын ажилтнууд Монгол Улсад таны өмнөөс бусад талуудтай гэрээ байгуулж таны бизнес, хөрөнгө оруулалтын хамгаалалтыг баталгаажуулна
- Монголд бусад талуудтай хамтран ажиллахад тань Таны бизнес, хөрөнгө оруулалтыг хамгаалахад дэмжлэг үзүүлнэ.



МОНГОЛ-ЯПОН ХАРИЛЦААНЫ ТОВЧООН


Монгол Улс болон Япон Улс хоорондын дипломат харилцаа 1972 оны 2 дугаар сарын 24-ний өдөр тогтсон. Одоогоор 1998 оноос "Иж бүрэн түншлэл"-ийн, 2010 оноос "Стратегийн түншлэл"-ийн харилцааг хөгжүүлж байна. Монгол Улс 1972 оны 6 дугаар сард Токио хотод, Япон Улс 1973 онд Улаанбаатар хотод тус тус Элчин сайдын яам байгуулжээ.

- Япон Улстай байгуулсан эрх зүйн томоохон баримтуудыг дурдвал, 2015 оны 6 дугаар сарын 2-ны өдөр хийгдсэн хэлэлцээр болох Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр юм.

- Мөн 2015 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улсын хоорондын хэлэлцээр хийгдэж байсан. Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг 2016 оны 5 дугаар сард байгуулж, 6 дугаар сарын 7-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.
- Япон Улсын Засгийн газраас 1977-2019 онуудад 120.2 тэрбум иенийн буцалтгүй тусламж, 54.2 тэрбум иенийн техникийн хамтын ажиллагаа, 157.9 тэрбум иенийн хөнгөлөлттэй зээл буюу нийт 332.4 тэрбум иен (3 тэрбум гаруй ам.доллар)-ийн зээл, тусламжийг манай улсад үзүүлсэн.

ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТОМООХОН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРӨӨС ДУРДВАЛ:

1 БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ



“ЯПОН-МОНГОЛЫН СУРГАЛТЫН ЭМНЭЛЭГ БАРЬЖ, БАЙГУУЛАХ ТӨСӨЛ”


7 тэрбум 985 сая иен



149-Р СУРГУУЛЬ

“УЛААНБААТАР ХОТЫН БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАРИЛГЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”

2 тэрбум 379 сая иен



109-Р СУРГУУЛЬ



53-Р СУРГУУЛЬ



75-Р СУРГУУЛЬ



2 ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ

“УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ ШИНЭ БУУДАЛ”

65.6 тэрбум иен

| № | ЗЭЭЛ | ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ |
|---|---|-----------------------------|
| 4 | Төсөв, нийгэм, эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлогын зээл | 850 сая ам.доллар |
| 5 | ЖДҮ-ийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээл | 80 сая орчим ам.доллар |
| 6 | “Инженер, технологийн дээд боловсрол” төсөл | 7.5 тэрбум иен |
| 7 | “Хөдөө Аж Ахуйн Салбарын Нэмүү Өртгийн Сүлжээний Мастер Төлөвлөгөөг Боловсруулах” Төсөл | 2 сая ам.доллар |
| 8 | “Малын эмч нарын чадавхыг дээшлүүлэх төсөл” – 2-р шат | 4.5 сая ам.доллар |

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН СӨРӨГ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛД:

Япон Улсын Засгийн газраас “COVID-19” цар тахлын сөрөг нөлөөг бууруулах дэмжлэг туслалцаа үзүүлсээр байна. Үүнд:

- ЖАЙКА-гийн Техникийн хамтын ажиллагаанаас гадна Олон улсын байгууллагаар дамжуулан эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэхэд зориулан 2 сая 90 мянган ам.долларын санхүүжилт олгосон.
- Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд төслийн бус буцалтгүй тусламжаар эрүүл мэнд, эмнэлгийн тогтолцоог сайжруулахад зориулан 1 тэрбум иенийн (9.3 сая ам.доллар) үнэ бүхий эмнэлгийн төхөөрөмжийг нийлүүлэхээр ажиллаж байна.
- Япон Улсын Засгийн газрын “Яаралтай хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр”-ийн хүрээнд манай улсад 25 тэрбум иен (ойролцоогоор 230 сая ам.доллар) олгох бэлтгэл ажил хийгдэж байна.

Эх сурвалж: ГХЯ


ЯПОН УЛСЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Япон улсаас 1990 оноос 2020 оны байдлаар Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 1 тэрбум ам доллар орчим байгаа нь нийт 123 орноос 9-д жагсаж байна. Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын 4.4 хувийг Япон улс эзэлж байна. Үүнийг салбараар нь авч үзвэл нийтийн хоолны салбарт 45 хувийг, Хөнгөн үйлдвэрт 8.23 хувь, Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлд 14 хувь,


Банк, санхүүгийн үйл ажиллагаа 9.6 хувь, бусад салбар 23.17 хувийг бүрдүүлдэг.

Япон улсаас Монгол Улсад бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалттай 670 компани байна. Үүнээс Худалдаа нийтийн хоолны салбар 423 аж ахуй нэгж буюу 63.13 хувь, хөнгөн үйлдвэр 10.30 хувь, Банк санхүүгийн үйл ажиллагаа 7.01 хувь, Аялал жуулчлал 2.69 хувь, бусад салбар 16.87 хувийг тус тус бүрдүүлдэг.


ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД БҮРТГЭГДСЭН ГАДААД ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ




ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН ГАДААД ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙ НЭГЖИЙН ТОО



1990-2020 ОНД ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД ОРСОН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ (АЖ АХУЙ НЭГЖЭЭР)



1990-2020 ОНД ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД ОРСОН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ (САЛБАРААР)



ХОЁР ТАЛЫН ХУДАЛДААНЫ ЭРГЭЛТ 2020 ОН:

Хоёр орны худалдааны эргэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 416.5 сая ам.долларт хүрч, өмнөх онтой харьцуулахад 30.7% буурсан дүнтэй байна. Манай улсын Япон Улс руу чиглэсэн экспорт 9.684 сая ам.доллар, импорт 406.7 сая ам.долларт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад экспорт 38.6% буурч, импорт 30.6%-иар өсжээ.

Экспортын гол нэрийн бараанд самнасан ноолуур, ноолууран бүтээгдэхүүн дийлэнх хувийг эзэлж, импортын гол нэрийн бараанд суудлын болон ачааны автомашин, нийтийн тээврийн хэрэгсэл болон цагаан будаа, нийлэг мяндсан давуу зэрэг бараа дийлэнх хувийг эзэлж байна.

Монгол, Японы худалдааны эргэлт /сүүлийн 5 жилийн байдлаар /
/сая ам.доллар/

| ОН | НИЙТ ЭРГЭЛТ | ИМПОРТ | ЭКСПОРТ |
|---------|-------------|--------|---------|
| 2015 он | 294.9 | 274.6 | 20.31 |
| 2016 он | 344.6 | 330.6 | 14.03 |
| 2017 он | 378.0 | 363.1 | 14.81 |
| 2018 он | 588.0 | 561.0 | 26.5 |
| 2019 он | 600.9 | 585.4 | 15.51 |
| 2020 он | 416.5 | 406.7 | 9.684 |



ЯПОН – МОНГОЛ

УЛСЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ



ЯПОН – МОНГОЛЫН 50 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭХ БЭЛТГЭЛИЙГ ХАНГАЖ БАЙНА

Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой 2022 онд тохιοхтой холбогдуулан энэхүү ойг өргөн хүрээнд ёслол төгөлдөр тэмдэглэхээр төлөвлөж байна. Монгол Улсын Засгийн газраас ойг тэмдэглэх ажлыг Зохион байгуулах хороог байгуулж дараах чиглэлээр арга хэмжээг зохион байгуулахаар ажиллаж байна.

Үүнд:

Эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны чиглэлээр
Соёл урлаг, спорт, сурталчилгааны чиглэлээр
Улс төрийн чиглэлээр

Эх сурвалж: ГХЯ



“ЗАСГИЙН ГАЗРЫН 100 ХОНОГ” АРГА ХЭМЖЭЭ ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн газар эмхлэн байгуулагдсан 100 хоногийн хугацаанд төлөвлөгөөнд туссан дараах ажлуудыг Үндэсний хөгжлийн газар хариуцан гүйцэтгэлээ.

- Ерөнхий сайдын дэргэд Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, дэмжих, Ерөнхий сайд болон Засгийн газарт бодлогын зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий “Хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл”, болон бизнесийн орчинд тулгарч буй саад бэрхшээлийг илрүүлэх, тэдгээрийг шийдвэрлэх хувилбаруудыг боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт танилцуулах, төр ба хувийн хэвшлийн хооронд бодлогын хэлэлцлийг өрнүүлэх механизм бүхий “Бизнесийн зөвлөл”-ийг байгуулах бэлтгэл ажлыг ханган гүйцэтгэлээ.

- Уг ажлын хүрээнд хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж, тэдний санал зөвлөмжийг нэгтгэн, зөвлөллүүдийн бүтэц, чиг үүрэг, бүрэлдэхүүний талаарх санал болон холбогдох журмуудын төслийг боловсруулав.

- Салбар бүрийн мэргэшсэн экспертүүдийн багийг /home doctors/ бүрдүүлж, хөрөнгө оруулалтын орчныг

сайжруулах, хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх хүрээнд хамтран ажиллана.

- Төр, хувийн хэвшлийн хэлэлцлийн механизмыг үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулж, тухайн орон нутгийн бизнес эрхлэгчдийн дуу хоолойг сонсож, тэдэнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж, шаардлагатай тохиолдолд Ерөнхий сайдын дэргэдэх бизнесийн зөвлөлөөр асуудлаа хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

- “ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУДАД ХЭРЭГЖҮҮЛЭХ 100 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ”-ний аргачлал, үнэлгээ, эрэмбэлэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яамтай хамтран гаргаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулав.

- Уг ажлын хүрээнд талуудын оролцоог бүрэн хангах зорилгоор олон улсын санхүүжүүлэгч байгууллага, хувийн хэвшил, салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, нийслэл, орон нутгийн удирдлагуудтай зөвлөлдөх цуврал уулзалт зохион байгуулсан. Эдгээр уулзалтуудад НҮБ, ОУВС, АХБ, Дэлхийн банк зэрэг олон улсын арваад байгууллагын 40 гаруй төлөөлөл, төр хувийн хэвшлийнхэн оролцож төслүүдийн шалгуур үзүүлэлт, анхаарах шаардлагатай асуудлуудын талаар

хэлэлцсэн. Үндэсний хэмжээний, хэтийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц төслүүдийг олон улсын түвшинд нийцсэн нотолгоонд суурилсан аргачлалаар эрэмбэлэхдээ эдийн засгийн өгөөжөөс гадна нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, хүн амд хүртээмжтэй байдал зэрэг олон үзүүлэлтийг харгалзан үзсэн.

- Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар хамтран 3 үе шатаар, 3 хувилбараар гаргасан энэхүү эрэмбэлэл нь урт хугацаанд манай улсын хөгжлийн дүр зургийг харах, цаашлаад хэрэгжүүлэлтийг хурдасгах зорилготой. Уг төслүүдийг Засгийн газрын 100 хоногийн хүрээнд олон нийтэд танилцуулсан.

- 100 төсөл, арга хэмжээнд орсон төслүүдээс хувийн хэвшил хэрэгжүүлэх боломжтой, эдийн засгийн өгөөжтэй, хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслүүдэд үндэслэн төслийн эмхэтгэл гаргаж, түүний бэлэн байдлыг хангах, хөгжүүлэх зорилгоор Төсөл хөгжүүлэлтийн санг бий болгоно.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭЭ БЭЛТГЭЖ БАЙНА

Олон улсаас хөрөнгө оруулалт татах сонирхолтой, тодорхой төсөлтэй үндэсний үйлдвэрлэгч, аж ахуйн нэгж, компани, стартапуудад зориулж төслөө чадавхижуулж, сайжруулахад нь дэмжих, цаашилбал, хөрөнгө оруулагчтай нь холбож өгөх зорилгоор “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”-ийг Үндэсний хөгжлийн газраас санаачлан, Ирбис Венчурс, Жи-Эм-Жи Консалтинг компанитай хамтран зарлаж, шалгаруулалтын үйл ажиллагаа амжилттай болж дууслаа.

2021 оны 4 дүгээр сарын 19-нд аялал жуулчлал, ХАА, газар тариалан, эрүүл мэнд, мэдээллийн технологи, барилга, хүнсний үйлдвэрлэл, гоёл, хувцас загвар, худалдаа, маркетинг, финтек, сэргээгдэх эрчим хүч зэрэг салбаруудын 46 төслийг Ирбис Венчурс компанийн зохион бүтээсэн “Irbis Oasis” цахим платформоор хүлээн авсан бөгөөд 4 дүгээр сарын 20-ны өдөр эхний шатны шалгаруулалтыг Үндэсний хөгжлийн газар, Ирбис Венчурс компанийн хамтарсан шүүгчдийн бүрэлдэхүүн хийж, 12 төслийг сонгон шалгаруулсан.

4 сарын 21-ний өдөр “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”-ийн эцсийн шатны

шалгаруулалтыг төр, хувийн хэвшлийн 14 төлөөллөөс бүрдсэн хараат бус шүүх бүрэлдэхүүнд эхний шатнаас шалгарсан 11 төсөлтэй (нэг төсөл өөрийн саналаар татгалзсан) танилцаж, тодорхой асуултуудыг асууж, зөвлөгөө зөвлөмж өгч, таван төслийг цахимаар шалгарууллаа. Уг шалгарсан таван төслийг дурдвал.

- ЧИМЭГЭ Системс /Программ хангамж, Voice tech, AI, NLP/
- Солонго Хараа компани /Эрүүл мэнд/
- Clinica App /Эрүүл мэнд/
- Urban Lily /Хөдөө аж ахуй/
- Zoson Fashion /Хөнгөн үйлдвэрлэл/

Эцсийн шатанд шалгарсан төслүүдийг нэг сарын хугацаанд “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”-т хамруулж, дотоод болон гадаадын хөрөнгө оруулагч, мэргэжилтнүүдээс хөрөнгө оруулалт татахад төслийн тооцоолол, давуу тал, онцлогийг тодруулж, хөрөнгө оруулагчдад танилцуулах, хөрөнгө оруулагчдыг төсөлдөө татан оролцуулах, хөрөнгө оруулагчтайгаа таатай, итгэлцэл бүхий харилцааг үүсгэх, цаашид хамтран ажиллах зэрэг арга барилд сургаж чадавхижуулах юм.

Бусад төсөл хөтөлбөрүүдийн адил ямар нэгэн санхүүгийн дэмжлэг үзүүлэхгүйгээр, шалгаруулалтад тэнцсэн төслүүдийг дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагч, менторуудаас үнэ цэнтэй зөвлөгөө, зөвлөмж авч сайжруулан, олон улсын тавцанд гарахад нь дэмжлэг үзүүлж, Үндэсний хөгжлийн газраас 5, 6 дугаар сард Япон, БНСУ-ын хөрөнгө оруулагчдад танилцуулах боломжийг олгож дэмжиж ажиллана.

Төрөөс зөвхөн томоохон мега төслүүдийг дэмжихгүйгээр ЖДҮ, стартапуудыг мөн адил дэмжиж, зөвхөн уул уурхайн салбараас хараат байхаас зайлсхийж, эдийн засгийг солонгоруулах чиг хандлага руу төр болон хувийн хэвшил илүүтэйгээр анхаарч, аж ахуйн нэгжүүдийг дэмжих “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”-ийн төслийн шалгаруулалтын үйл ажиллагааг <https://oasis.irbis.sg/> платформоор хүлээн авч, цахимаар хоёр шатны шүүлтийг нээлттэй, ил, тод шударгаар зохион байгуулсан нь шинэлэг, онцлог боллоо.





ЧИМЭГЭ

Мөн чанартаа автоматаар яриа таних (ASR) интерфейс бүхий (API) бүтээгдэхүүн нь цахим хэл шинжлэл (NLP) дээр суурилан яриаг барьж, үгсийг харгалзах байрлалын хамт бичгээр гаргадаг (эсрэгээр нь бичвэрийг ярианд хөрвүүлэх бүтээгдэхүүн (TTS))

Энэхүү технологийг ашиглан бүх төрлийн электрон хэрэгслийг хүний хэлсэн тушаалаар удирдах боломжтой болно. Тус технологи нь англи, франц, герман гэх мэт өндөр нөөцтэй хэлээр ярьдаг бүс нутгийн бүхий л салбарт үр ашигтай, цаг хэмнэсэн, тав тухтай байдлыг бий болгодог. Харин нөөц багатай хэлнүүдийн хувьд ихээхэн хэрэгцээтэй байсан ч шийдэгдээгүй байсаар байна. Энэ орон зайг нөхөх зорилгоор Чимэгэ системс нь NLP дээр суурилсан API бүтээгдэхүүнээ монгол хэл дээр гаргаж эхэлсэн бөгөөд бизнес, үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх өргөн боломж байгааг олж харлаа.


Чимэгэ Монголын зах зээлд гаргасан STT, TTS бүтээгдэхүүнүүд нь ашиглалтын зардлыг бууруулахад чухал нөлөө үзүүлж байна.

“

Юуны өмнө үндэсний гарааны компаниудаа дэмжиж, сайхан үйл ажиллагаа зохион байгуулсан та бүхэнд баярлалаа. Манай баг голдуу программ хангамж, хэл шинжлэл суурьтай хүмүүс байдаг тул бизнес, хөрөнгө оруулалтын ийм хөтөлбөрт заавал орох ёстой гэж үзээд оролцож, эхний байранд шалгарсанд баяртай байна. Шалгаруулалт ил тод, газар дээр нь шууд санал хураалтаар түргэн шуурхай дүгнэж байсан нь үнэхээр таалагдлаа. Бидэнд хөрөнгө оруулалтын болон бизнес хөгжлийн талаар тодорхойгүй маш олон асуулт байдаг тул энэ хөтөлбөрийн хүрээнд түүндээ зөв хариулт авна гэдэгт итгэлтэй байна.

-С.Бадрал, Үүсгэн байгуулагч

ВЕБ: www.chimege.mn
ИМЭЙЛ: info@chimege.mn
ФЭЙСБҮҮК: [chimegesystems](https://www.facebook.com/chimegesystems)
ТВИТТЕР: [chimegesystems](https://twitter.com/chimegesystems)
УТАС: 77111140





СОЛОНГО ХАРАА ЗАСЛЫН ЛАЗИК ТӨВ

Дэлхий нийт тэр дундаа Азийн бүсийн орнуудын иргэдийн дунд маш эрчимтэй нэмэгдэж байгаа нүдний эвэрлэгийн хугарлын гажиг буюу хараа муудах эмгэгийг high tech, yr чадвар, know how-ийн тусламжтайгаар тодорхой хэмжээнд шийдвэрлэх, үр дүнтэй, ээлтэй, ирээдүйтэй "гоё" бизнес бий болгох зорилготой.

ХБНГУ /Герман/-ын нүдний лазер хагалгааны технологиор тэргүүлэгч Schwind брэндийн AMARIS 1050RS машин авснаар жилд 600-800 лазер хагалгаа хийгдэнэ. Энэхүү машин нь эвэрлэгийн хэлбэр засах Лазер туяаны хурд 1050 HZ буюу одоо ашиглагдаж байгаа машинаас 10 дахин хурдан /4-8 сек хийгдэнэ/, 7D tracking буюу нүдний хөдөлгөөний дагаж лазераар буудах технологи шинээр нэвтэрсэн.

Энэ нь лазер буудалтын байг оновчтой болгож, зүслэг хийгдсэн эвэрлэгийн бүрэн cover хийх хугацааг маш богино болгож өгснөөр лазер хагалгааны үр дүнг хийлгэсэн тэр даруй мэдрэх боломжийг олгож байна.

Мөн энэ машин нь Монголд шийдвэрлэх боломжгүй кератоконус-ийн эмчилгээг давхар хийгддэг давуу талтай тул гадагшаа явж хийгдэж байгаа эмчилгээг энэ төвд төвлөрүүлэх боломжтой болно.

“

Үндэсний хөгжлийн газраас санаачлан зохион байгуулж буй төсөл чадавхижуулах хөтөлбөр нь Ковид-2019 цар тахлын үеийн хамгийн үр дүнтэй ажил болж байна гэж бодож байна. Сонгон шалгаруулалт цахимаар маш сонирхолтой, шинэлэг, богино цаг хугацаанд, Pitch deck загвар ашиглан төслөө танилцуулсан нь яг л Шарк танк нэвтрүүлэгт орж буй мэт сэтгэгдэл төрүүлсэн. Олон олон Монгол залуусын "гоё" төслүүд, олон улсад гарч хөрөнгө оруулалт босгох гүүр, дэмжигч нь байгаасай гэж хүсэж байна. Ирбис Венчурс, Жи-Эм-Жи Консалтинг компаниудын сургалт, мэдээлэлд үнэхээр талархаж байна.

-Г.Чинзориг, Гүйцэтгэх захирал

ВЕБ: solongohospital.mn
 ФЭЙСБҮҮК: [SolongoClinic](https://www.facebook.com/SolongoClinic)
 ИМЭЙЛ: Info@solongohospital.mn
chinzog@gmail.com
 УТАС: 88885578

ТАНЫ ГАРТ БАГТАХ ДИЖИТАЛ КЛИНИК

Клиника нь гар утсанд суурилсан аппликейшн бөгөөд телемедицин хэлбэрээр эмч эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрэглэгчид хялбараар хүргэх гарааны бизнесийн шийдэл юм. Монгол улсын хэмжээнд улсын эмнэлгээр үйлчлүүлэхийн тулд дунджаар 5-21 хоног, хувийн эмнэлгээр үйлчлүүлэхийн тулд 1-3 хоног хүлээх шаардлагатай болдог.

Бид гар утсанд суурилсан телемедицин үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлснээр иргэдэд өгөх эрүүл мэндийн зөв мэдлэг мэдээллийг хүртээмжтэй болгох, хэрэглэгчид тусламж үйлчилгээг цаг алдалгүйгээр хүргэх зэрэг гол асуудлыг шийдэж байгаа ба уг шийдэл нь цар тахлын үед биеэр уулзах боломжгүй байгаа эмч өвчтөн хоёрын хоорондын зөв шийдлийг гарган өгч байгаа юм.

Цаашид бид Клиника аппликейшнийг онлайн эмийн сантай, эмчийн байнгын хяналттай, хиймэл оюун ухаанд суурилсан үйлчилгээтэй болгон хөгжүүлэхээр ажиллаж байна.

ВЕБ: www.clinica.mn
ФЭЙСБҮҮК: [Clinicaapp](https://www.facebook.com/Clinicaapp)
ИМЭЙЛ: Baasandorj.d@clinica.mn
УТАС: 88885578

“

Энэ хөтөлбөрт хамрагдаж байгаадаа Клиника-н хамт олон туйлын баяртай байна. Зохион байгуулах үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт, шүүгчдийн үнэлгээ зэрэг нь олон улсын хэмжээний чанартай байсан. Бид бүхэн хөрөнгө оруулагчтай холбогдох стратегийн түншлэл болон ментор зөвлөгөөнүүдэд тусламж дэмжлэг үзүүлж байгаад талархаж байна. Эдгээр зүйлс нь бидний эрүүл мэндийн тусламж үйлчилгээг олон нийтэд түгээх зорилгыг нэг шатаар ахиулж байна.

-Д.Баасандорж, Гүйцэтгэх захирал

УРБАН ЛИЛИ

Монгол улс 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжин нийгэм, эдийн засгийн байдал өөрчлөгдөн бүх зүйл өөр өөрийн гэсэн орон зайгаа эзлэн хөгжиж байна. Гэсэн хэдий ч манай улсад гоёлын цэцгийн аж ахуйн хөгжил сул, энэ чиглэлийн бизнесийн орон зай хоосон байна.

Учир нь дотооддоо гоёлын цэцэг тариалдаг компани байхгүй бөгөөд бараг 100 хувь

импортоор гоёлын цэцгээ авдаг. Статистик мэдээнээс харахад импортоор орж ирж буй цэцэг жил бүр өссөн дүнтэй байна. Манай компани нь гоёлын цэцэг тариалах туршилт судалгааг Монголд 2015 оноос эхлүүлсэн.

Сүүлийн 3 дахь жилдээ массын тариалалт хийж намрын хугацаанд дотоодын цэцгийн дэлгүүрүүдийг лили цэцгээр хангаж байна. Өнгөрсөн хугацаанд бид Монголын цаг

уур, нөхцөлд амжилттай ургах сортуудыг тогтоож, хөрсний агууламж, бүтэц, усны чанар ургалтад хэрхэн нөлөөлж байгааг, мөн зах зээлийн багтаамжаа тодорхойлж авсан.

Төслийн хүрээнд үндсэн тариалах цэцэг бол Лили (Сараана) бөгөөд төрөлжүүлэх байдлаар өөр 10 аад төрлийн 20 орчим сортын цэцэг тариалах боломжтой болно.

URBAN LILY

“ Анх “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”-ийн талаар телевизийн мэдээний дундуур сонссон. Үнэхээр Start-up компаниудын өмнө тулгардаг хамгийн том асуудлыг шийдэх шийдлийн гарц, алтан боломж гэж хүлээн авсан.

Төсөл чадавхижуулах хөтөлбөрийн тухайд улсын хөгжлийн бодлого тодорхойлох төрийн байгууллага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өндөр туршлага бүхий хувийн хэвшил хамтран хэрэгжүүлж байгаа гэдгээрээ онцлогтой санагдаж байгаа ба мэргэжлийн түвшинд, үнэтэй мэдлэг, чадвар олгоно гэсэн маш их хүлээлттэй байна.

Шалгаруулалт эхнээсээ ил тод нээлттэй болсон. Эцсийн шатны шалгаруулалтад төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөл болох 20 шүүгч шалгаруулалтыг хийж, төслүүд дээр үнэтэй зөвлөгөө өгч байсан нь шалгаруулалтыг үнэн бодитой болгосон гэж үзэж байна. Манай компанийн тухайд энэ боломжийг маш сайнаар, үр дүнтэй ашиглан, дутуу байгаа мэдлэг, туршлагаа хуримтлуулан авах болно.

-Б.Амарсанаа, Гүйцэтгэх захирал

ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ

/SUSTAINABLE FASHION/

SUSTAINABLE CASHMERE
Z O S O N
A source from upcycled fabrics

Манай компанийн гол уриа нь brings sustainability буюу байгальд ээлтэй брэнд болох бөгөөд ноолуурын үйлдвэрүүдийн хаягдлыг хямд үнээр худалдан авч бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж байгаа нь олон улсад брэндийн чиг хандлага sustainable fashion болсонтой мөн холбоотой. Ноос ноолуурын хувьд түүхий эдийн гарал үүсэл, түүнийг бэлтгэх эко систем нь үйлдвэрлэгчдийн хувьд сорилт болж

байгаа бөгөөд бидний хувьд их хэмжээгээр үйлдвэрлэх бус, хариуцлагатайгаар үйлдвэрлэх зорилго тавьдаг. Компанийн үйлдвэрлэлийн 10%-ийг ноолууран бүтээгдэхүүн эзэлдэг ба бид Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг ноолуурын үйлдвэрүүдийн эсгүүрийн хаягдлыг дахин ашиглах замаар шинээр бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийдэг. Төслийн хүрээнд энэ үйлдвэрлэлээ 40%-д хүргэх, байгальд

ээлтэй ноолууран (Sustainable cashmere) бүтээгдэхүүний брэнд үүсгэх гол зорилготой. Мөн төслийн хүрээнд зөвхөн ноолуур бус дэлхийд ховорт тооцогддог түүхий эд болох сарлагийн хөөвөр, тэмээний ноосны эко системийг бий болгож, үйлдвэрлэгч болох төлөвлөгөөтэй.



SUSTAINABLE CASHMERE
Z O S O N
A source from upcycled fabrics

“ Үндэсний хөгжлийн газар болон хөрөнгө оруулалтын мэргэжлийн зөвлөх багийн дэмжлэгтэйгээр зохион байгуулагдаж буй энэхүү чухал арга хэмжээнд оролцох боломж олдсонд туйлын баяртай байна. Энэ арга хэмжээний үр дүнд бидний танилцуулж буй төсөл маань амжилтад хүрнэ гэдэгт итгэлтэй байна. Тогтвортой хөгжлийн бизнесийг тууштай дэмжиж буй арга хэмжээг зохион байгуулагчдадаа талархлаа илэрхийлье. -Р.Ариунболд, Удирдах захирал

“ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУДАД ХЭРЭГЖҮҮЛЭХ 100 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ”-ний хүрээнд 3 цуврал уулзалтууд зохион байгуулагдлаа

“Тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээ”-ний хүрээнд олон улсын санхүүжүүлэгч байгууллагууд, хувийн хэвшил болон салбарын мэргэжлийн холбоодын төлөөлүүдтэй зөвлөлдөх цуврал уулзалтыг зохион байгууллаа.

Засгийн газар үүрэгт ажлаа эхлүүлсний 100 хоногийн хүрээнд “Тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээ”-ний цогц эрэмбэлэлтийг хийж, төр хувийн хэвшлийн хоорондын уялдаа зохицуулалтыг хангаж ажиллах үүргийг Үндэсний хөгжлийн газар (ҮХГ), Сангийн яам болон ЗГХЭГ-ын хамт хүлээсэн.

Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар хамтран 3 үе шатаар, 3 хувилбараар гаргасан энэхүү эрэмбэлэл нь урт хугацаанд манай улсын хөгжлийн дүр зургийг харах, цаашлаад хэрэгжүүлэлтийг хурдасгах зорилготой. Уг эрэмбэлэлийн хүрээнд 3 зөвлөлдөх уулзалтыг олон улсын санхүүжүүлэгч байгууллагууд, хувийн хэвшил болон салбарын мэргэжлийн холбоодын төлөөлүүдтэй цахимаар зохион байгуулсан.

100 төслийг ийн эрэмбэлэхдээ төсвийн ачааллыг ихэсгэхгүй, өрийн таазыг нэмэгдүүлэхгүйгээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн шинэлэг арга механизмуудыг нэвтрүүлэх боломжийг Үндэсний хөгжлийн газар өөрийн чиг үүргийн хүрээ 2021 оны 4-р сарын 13-ны өдөр зохиогдсон уулзалтад Нэгдсэн Үндэстний Байгууллага, Олон Улсын Валютын Сан, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн банк тэргүүтэй 10 гаруй олон улсын байгууллагын 40 гаруй төлөөлөл оролцсон бөгөөд уулзалтыг нээж улс орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг байгуулсан хамгийн том сан болох Уур амьсгалын Ногоон сангийн гадаад харилцаа эрхэлсэн захирал С.Оюун үг хэлсэн юм.

Цаашид манай эдийн засгийн суурь болсон түүхий нүүрсэн дээр суурилсан төслүүдийг санхүүжүүлэх өртөг өндөр хийгээд хомс болох тухай тиймээс төслүүдийн бэлэн байдлыг хангахдаа байгаль орчинд ээлтэй, ногоон шалгуурыг тавихын чухлыг тэр онцолсон бол бусад олон улсын байгууллагууд түүнтэй дуу нэгтгэйгээр уг асуудлыг хөндөж байлаа.



THE THINK GLOBAL CONFERENCE 2021

Олон улсын хөрөнгө оруулагчдын Тинк Глобал цахим арга хэмжээний өдрүүд тохиож байна. Олон улсын худалдааны зөвлөлөөс 2021 оны 04 сарын 12-16-ны өдрүүдэд “The Think Global Conference” цахим арга хэмжээг зохион байгуулж байна. Энэхүү арга хэмжээнд 79 орны 175 илтгэгчид мэдээлэл хийх ба олон улсын хэмжээний нийт 3500 бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид оролцож байна.

Үндэсний хөгжлийн газрын дэд дарга Б.Булганчимэг 2021 оны 04 сарын 12-ны өдрийн хуралд оролцож Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлийн талаар мэдээлэл хийж Монгол Улсад хөрөнгө оруулах боломжийн талаарх асуултуудад хариуллаа.

ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН ФОРУМ ЕВРОЧАМБЕР

2021 оын 4 дүгээр сарын 13-ны өдөр Монгол улс дахь Европын төлөөлөгчийн газраас Монгол улсын хөрөнгө оруулалтын орчны талаар цахим уулзалтыг зохион байгууллаа. Цахим хэлэлцүүлгийн илтгэгчээр Европын Холбооны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын орлогч дарга Марко Ферри, Үндэсний хөгжлийн газрын дэд дарга Б.Булганчимэг, ЕСБХБ-ны Засаглал ба улс төрийн асуудал эрхэлсэн дэд захирал Анастасия Родина, KPMG Mongolia хариуцсан түнш Марк Эберст, Thies Mongolia компанийн гүйцэтгэх захирал Леон Коэтцернар нар оролцов.

Монгол Улс дахь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэхтэй холбоотой тулгамдсан асуудлуудад гадаадын хөрөнгө оруулалттай тэргүүлэгч компаниудын төлөөллүүд санал бодол, туршлагаа хуваалцсан сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүллээ.

“МОНГОЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ИТГЭЛИЙГ ХЭРХЭН СЭРГЭЭХ ВЭ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛОВ

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2021 оны дөрөвдүгээр сарын 13-нд “Хөрөнгө оруулагчдын итгэлийг хэрхэн сэргээх вэ” сэдэвт сар бүрийн уулзалтаа цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Хэлэлцүүлгийн илтгэгчээр УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Үндэсний хөгжлийн газрын дэд дарга Б.Булганчимэг, Олон улсын санхүүгийн корпорацийн хувийн хэвшлийн ахлах мэргэжилтэн Д.Жигжидмаа нар оролцов. Энэхүү уулзалтад АмЧам Монголын гишүүд, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчид болон гадаадын элчин сайдын яамдын төлөөлөл оролцлоо.

ҮХГ-ын дэд дарга Б.Булганчимэг хөрөнгө оруулалтын шинэчлэл хийж, илүү таатай хууль эрх зүйн орчин, нээлттэй зах зээлийг бий болгохоор зорилт тавин ажиллаж байгааг онцлон дурдаад, сонирхсон асуултуудад хариуллаа.



МАЛ АЖ АХУЙ САЛБАР



Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны чиглэлүүдэд “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих” зорилгыг дэвшүүлсэн ба Мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зэрэг тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхээр төсөл, хөтөлбөрүүдийг эхлүүлсэн.

Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар нь Дотоодын нийт бүтээгдэхүүний 31 хувийг бүрдүүлдэг тул үйлдвэрлэлийн нөөц болон дотоодын зах зээлийг харьцуулахад Монгол Улс нь тогтвортой мал аж ахуй, газар тариалангийн салбарт түшиглэсэн экспортын баримжаатай хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой.

Олон Улсын Санхүүгийн Корпорацийн зүгээс хөдөө аж ахуйн хөгжлийн асуудалд анхаарч “Хөрөнгө оруулалтын бодлого, хөдөө аж ахуйн салбар дахь хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийг 2016 оны намраас хэрэгжүүлж байна. 2017 онд Монгол Улсын мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй, сүү боловсруулах, мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрлэл болон ноолуурын гүн шатны боловсруулах үйлдвэрлэлд гадаадын шууд хөрөнгө оруулалт татах боломжтой болохыг судалгаагаар тогтоосон.

Эдгээрээс махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй Монгол Улсын махны экспорт нэмэгдүүлэхэд онцгой үүрэгтэй тул бусад орны махны эрэлт хэрэгцээ, туршлага болон хөрөнгө оруулах сонирхлыг дэмжих үйл ажиллагаа явуулсан болно. 2018 оны 5 сард Япон Улсын KNS компаний захирал ноён Цукаса Каедагийн Вагю төслийг монголын бизнес эрхлэгч нарт танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулж хэд хэдэн шинэлэг санааг олж авсан болно.

Үүний дагуу махны салбарт тэргүүлэх чиглэлээр ажиллаж байгаа төлөөллүүдийн дунд туршлага солилцох хурал, уулзалт удаа дараа зохион байгуулж, 2019 оны 6 сард Казахстан Улсын Казбиф компаний үйл ажиллагаатай танилцах бизнес аяллыг зохион байгуулсан.

Аялаас олж авсан мэдлэг мэдээллээ үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн жишээ олон байна. Тэдгээрийн нэг нь хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт татах стратеги төлөвлөгөөг Үндэсний хөгжлийн газартай хамтран боловсруулсан бөгөөд тус баримт бичгийг батлах тал дээр тус газар ажиллаж байгаа.

Мөн Үхэр бордох аж ахуйн гарын авлага номыг 2020 оны 10 дугаар сард гаргаж хувийн хэвшил, төр засгийн төлөөлөлд өгсөн. Энэ ном үхэр бордох үйл ажиллагаанд шаардагдах

гарааны хөрөнгө оруулалтыг тооцоолон гаргасан нь дотоод, гадаадын хөрөнгө оруулагч нарт тустай болох болов уу.

Түүнээс гадна Японы махны бизнес хийх сонирхолтой хөрөнгө оруулагч нартай хамтран ажиллах чадвар бүхий монгол аж ахуй эрхлэгч, кластер хөгжүүлэхэд энэ ном ихээхэн тустай юм.

Энэхүү гарын авлагыг өөрийн орны үхэр бордож буй алдаа оноо мөн олон улсын, ялангуяа АНУ-ын Глобалбиф, Казакстаны Казбиф гэх мэт компаний туршлага, мөн олон улсын болон дотоодын экспертүүдийн оролцоотойгоор бэлтгэсэн нь энэ төрлийн бизнес эрхэлж буй болон эрхлэхээр зорьж буй хүмүүсийн талархлыг хүлээсэн, эрэлт хэрэгцээтэй ном болоод байна.

Уг номын нээлтийн ажиллагаанд Д.Бямбаа, /"Хирай" Япон үхрийн фермийн малзүйч, Японы Киото ИС-ийн, Хөдөө аж ахуйн сургуулийн магистр/ оролцон одоо ажиллаж буй өөрийн фермийн үхрийг тэжээх, арчлах, маллагааны талаар танилцуулан, монголчууд үхэр бордох болон махны үхрийн аж ахуй эрхлэхэд гол анхаарах зүйлүүдийн талаар санал бодол, туршлагаа хуваалцсан нь үр дүнтэй, сонирхол татсан ажлын нэг болсон.

Төслийн зүгээс махны үхрийн үржлийн аж ахуй, үхэр бордох аж ахуйн тэжээл, тэжээллэгийн асуудал тулгамдаад байгаатай уялдуулан энэ талаар цахим уулзалтыг 2021 оны 3 сарын 4 ний өдөр зохион байгуулсан.



Уулзалтад Японы Киото Их сургуулийн Хөдөө аж ахуйн сургуулийн Дэд Профессор ноен Китагава Масаюуки, тус сургуулийн магистрант Д. Бямба, "Хирай" Япон үхэр фермийн малзүйч, өөрийн орны судлаачдын хийсэн малын тэжээл, тэжээллэгийн судалгааны талаар маш сонирхолтой илтгэл тавьсан. Японы махны үхрийн аж ахуй, махны үхэр тугал байхаас нь хэрхэн маллах, өсгөж бордож буй талаар танилцуулгыг сонссон тус цахим хуралд оролцсон хүмүүст санаа авах машинд өгөөжтэй үйл явдал болсон.

Цаашид тус корпорацийн зүгээс махны салбарын хүнсний аюулгүй байдал, хөрөнгө оруулалт татах, экспортын үйл ажиллагаанд гарч буй саад тотгорыг багасгах, шинэ технологи ашиглах тал

“ ЭДГЭЭР АЖЛЫН САНХҮҮЖИЛТИЙГ ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС БИДЭНД ОЛГОСОНД ТАЛАРХАЖ БУЙГАА ЭНЭ ДАШРАМД ИЛЭРХИЙЛБЕ.

дээр шинэ төсөл эхлүүлэхээр ажиллаж байна.

Энэхүү ажлын урьдаар Олон Улсын Санхүүгийн корпорацийн зүгээс Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын асуудалд анхаарлаа хандуулж хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийг боловсруулахад техникийн туслалцаа үзүүлж улмаар тус хууль 2013 онд батлагдсан билээ.

Хууль батлагдсанаас хойш хуулийн хэрэгжилтэд туслалцаа үзүүлж ялангуяа хувийн хэвшилд шинэ дадлуудыг нэвтрүүлэхэд шаардлага бүхий мэдлэг мэдээллийг хүргэх тал дээр ажиллаж хоол үйлдвэрлэгч бизнес эрхлэгчдэд зориулсан багц зөвлөмж бүхий 1500 гаруй хувь гарын авлагыг нийтийн хоолны бизнес эрхлэгч болон эрүүл ахуй хяналтын байцаагч нарт тус тус хүргүүлсэн билээ.



МОНГОЛ ЗӨГИЙН ЯПОН МЕНЕЖЕР – МИХАЧИ ЗӨГИЙН БАЛ

Монгол Улсад суурьшин 24 дэх жилдээ амжилттай ажиллан амьдарч буй Томоко Ибүкуро гэх Япон эмэгтэйн эрхлэн явуулдаг “Михачи” ХХК-г онцолж байна.

“Михачи” ХХК нь Монгол Улсын Сэлэнгэ аймагт зөгийн аж ахуй эрхэлдэг бөгөөд зөгий үржүүлэг, зөгийн балын үйлдвэрлэл, зөгийн балын худалдаа гэх 3 төрлийн үйлчилгээ үзүүлдэг. Зөгийн 350 бүл өсгөн бүл бүрээс 55 кг бал хураан авдаг. Энэхүү компани нь зөгийн бал үйлдвэрлэлийн том компани биш хэдий ч зөгийн нэг бүлээс хураан авч буй балын хэмжээгээр ижил төрлийн бизнес эрхлэгчдээ манлайлдаг.


Монгол Улс жилд гадаадаас 300 тонн зөгийн бал худалдаж авдаг бол дотоодын

үйлдвэрлэгчид ердөө 100 тонныг нийлүүлдэг учраас импортыг орлох орон зай хангалттай аж. Тиймээс тус компани нь дэлхийн жишиг стандартыг мөрдөж, аюулгүй, эрүүл, амттай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхдээ үйл ажиллагаа тасралтгүй сайжруулах, дотоодын зах зээлээ хангах, цаашид гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэхээр зорин ажиллаж байгаа юм байна.

Тухайн компанийн хувьд Монгол Улс, Япон Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрээр Монголын зөгийн бал импортын татварын хөнгөлөлттэй бараанд орсон бөгөөд үүний хүрээнд Япон Улс руу анхны экспортоо хийсэн бөгөөд тус улсын хүнсний дэлгүүрүүд болон интернэт худалдаагаар амжилттай борлуулагдаж байна.



Михачи ХХК захирал
ТОМОКО ИБУКУРО



ВЕБ: <http://www.mihachi.mn/>
ФЭЙСБҮҮК: [MIHACHI / МИХАЧИ MONGOLAN BEEKEEPING COMPANY](#)
ИМЭЙЛ: tomoko@mihachi.mn

МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН БРЭНД ГУАМАРАЛ

Япон Улсын "Такаражима Жапан" ХХК нь анх Монгол Улсын чацарганыг Япон Улсын зах зээлд танилцуулах зорилгоор чацарганын түүхий эдийг ашигласан "Made in Japan" гоо сайхны болон эрүүл мэндийн ГУАМАРАЛ брэндийг үүсгэж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Тус компани нь түүхий эдийн хувьд Монгол Улсын "Шар Доктор" ХХК-тай бүтээгдэхүүн

импортлох хамтын ажиллагааны гэрээтэйгээр хамтран ажилладаг. Монгол Улсын Увс, Сэлэнгэ аймгуудад ургадаг хамгийн сайн чанарын чацарганыг дотоодын үйлдвэрт боловсруулан Монголоос шууд импортлож, Японд эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг.

Чацаргана жимсийг ашиглан амин дэмийн хэрэгцээгээ нэг дор хангах, дархлаагаа дэмжих, элдэв өвчлөлөөс сэргийлэх, биеийн

эрч хүч сэргээх чацарганын ундаа, жүүс, тос үйлдвэрлэхээс гадна эмэгтэйчүүдэд зориулсан гоо сайхны иж бүрдэл бүтээгдэхүүн, саван зэргийг үйлдвэрлэж, Япон Улсын Ибараки аймгийн Цүкүба хотод байрлах өөрийн нэрийн дэлгүүр болон интернэт худалдаа /Amazon, Rakuten/ ашиглан эцсийн бүтээгдэхүүнээ амжилттай борлуулсаар байна.

БЕБ: <https://guamaral.com/>



МОНГОЛ МАЛЫН АРСЫГ ДЭЛХИЙД – MONY ЧИХМЭЛ БӨМБӨГ



Япон Улсын “Ямагучи Сангёу” ХХК нь “Хүн болон байгальд ээлтэй арьс боловсруулалт”-ын технологийг хоёр орны харилцан дэмжлэгтэйгээр Монгол Улсад нэвтрүүлэн RUGBY бөмбөгийн хэлбэртэй MONY /Mongolia + Yamaguchi/ чихмэл бөмбөгийг Монгол Улсад үйлдвэрлэн Япон Улсын зах зээлд борлуулж байна.

Монголын хонины арьсыг “Рассети” технологиор боловсруулж, боловсорсон арьсаар MONY чихмэл бөмбөгийг үйлдвэрлэдэг байна. Энэхүү арьс нь хог хаягдалгүй, хүн болон байгальд ээлтэй, мөн

бага насны хүүхдэд ч хор нөлөөгүй гэдгээрээ онцлог юм.

MONY чихмэл бөмбөгийг ашиглан гэр бүл болон ажлын хамт олонтойгоо нас харгалзахгүй хүн бүхэн хийх боломжтой маш амархан “RUGBY дасгал”-ыг хийж, дасгал хөдөлгөөнөөр дамжуулан эрүүл мэндээ дэмжих боломжтой юм.

Тухайн бүтээгдэхүүн Япон Улсын зах зээлд гарсны дараагаар тус улсын компаниуд худалдан авч эхлэн ажил эхлэхийн өмнө “RUGBY дасгал”-ыг хийж, ажлаа эрч хүчээр

дүүрэн эхлүүлдэг болжээ.

“Ямагучи Сангёу” ХХК нь энэхүү төслөөрөө дамжуулан Монгол малын арьсыг дэлхийд таниулж, Монголын аж үйлдвэрт нэмэр оруулахын сацуу нийгмийн болоод байгалийн бохирдлын асуудлыг шийдэхэд хувь нэмэр оруулахаар зорин ажиллаж байна.

MONY чихмэл бөмбөгийг дараах холбоосоор орж худалдан авах боломжтой.

<http://camp-fire.jp/projects/view/346467>



МОНГОЛ ОРНЫ ХАЛУУН РАШААН

ОНОНГИЙН ХАЛУУН РАШААН

Хэнтий аймгийн Батширээт сумын төвөөс баруун тийш 120 км, Хэнтийн нурууны салбар Дуут Яаны хойд талд Онон голын эрэгт оршдог. Ононгийн рашаан нь Их, Бага гэж хоёр хэсэгт хуваагддаг ба Бага халуун рашаан нь Их халуун рашаанаасаа зүүн тийш 8 километр буюу Дуут Яаны өвөр хөндийд жижиг толгодын ар талд байрладаг. Өмнө нь Ононгийн халуун рашаанд 108 худаг байсан ч, байгалийн үзэгдэл болон бусад нөлөөллөөс хамааран одоогоор 10 худаг хэвийн ашиглагдаж байгаа.

Ононгийн халуун рашаан нь бага зэрэг хүхэрт устөрөгч, хийн үнэртэй, өнгөгүй тунгалаг рашаан бөгөөд нийт 24 ундаргатай, тус бүр 14-98 градус байдаг. Уг рашаан үе мөчний үрэвсэл, бөөрний даралт, бруцеллёз, цусны даралт, хамуу болон арьс өнгөний өвчин, чихрийн шижин, шар ус, хуян зэрэг өвчнийг анагаан эдгэрүүлэх увдистай.

ШАРГАЛЖУУТ РАШААН

Шаргалжуут рашаан нь Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт буюу Улаанбаатар хотын төв цэгээс 650 км зайтай байдаг. Боржин чулууны гүнээс ундрган гарах 108 төрлийн халуун, хүйтэн рашаантай Шаргалжуут рашаан нь Монгол орны өөр хаана ч байхгүй аялал жуулчлал, сувиллын цогцолбор газар юм.

Рашааны халууны хэмжээ их, сул эрдэсжилттэй тул биеийн дулааныг дээшлүүлэх, үрэвслийг түргэн илаарьшуулах, үе, булчин, ясны архаг өвчнийг эмчлэхэд тохиромжтой. Арьсан дахь мэдрэлийн судсыг цочроож цусны хөдөлгөөн, бодисын солилцоо, дотоод шүүрлийн ажиллагаанд нөлөөлдөг тул үе мөчний архаг үрэвсэл, эмэгтэйчүүдийн болон арьсны өвчин, амьсгалын замын өвчнийг эмчлэх увдистай.

“Рашаан”-ыг шинжлэх ухааны үүднээс тайлбарлавал, физикийн болон химийн өвөрмөц шинж чанар бүхий эмчилгээний ач холбогдолтой байгалийн ус, шавар юм. Харин “Рашааны орд” гэдэг нь газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтсон рашаан агуулж байгаа газар.

270 гаруй рашаантай төстэй харз, булгууд байдаг ба олон улсын эмчилгээний зориулалтын рашааны шалгуурыг хангасан 130 гаруй халуун, хүйтэн рашааны орд Монгол орны нутаг дэвсгэрт байдаг.

- Халуун рашаан 42
- Нүүрс хүчлийн хүйтэн рашаан
- 60 гаруй
- Халуун уур 1
- Рашаантай төстэй усны үелэл: 30 гаруй
- Эмчилгээний онцгой бүрэлдэхүүнгүй боловч эмчилгээнд тустай усны илрэл: 10 гаруй

“АНД ГЛОБАЛ”

АМЖИЛТЫН ТҮҮХ



Энэ удаагийн “АМЖИЛТЫН ТҮҮХ” буландаа бид дэлхийд өрсөлдөхүйц өндөр үр чадвартай Монгол инженер, Монгол хөгжүүлэгч залуусаар багаа бүрдүүлэн хамтын хүчээр технологийн салбарт шинэчлэлийг хийж, зах зээлийн чиг хандлагыг өөрчлөхөд өөрсдийн хувь нэмрээ оруулан ажиллаж буй “АНД ГЛОБАЛ” ХХК-ийг онцолж, тус компанийн Гүйцэтгэх захирал Б.ХОС-ЭРДЭНЭТЭЙ ярилцлаа.

Сайн байна уу, Танд энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны өмнө бидний урилгыг хүлээн авч, энэ удаагийн тусгай дугаарын зочноор оролцож байгаад баярлалаа. Ярилцлагаа “Анд Глобал” ХХК-ийн талаарх яриагаар эхэлсэн нь зүйтэй болов уу. Та өөрийгөө болон компанийнхаа талаар танилцуулахгүй юу?

Сайн байна уу, компани төлөөлөн та бүхэнтэй ярилцах боломжийг олгосонд баярлалаа. Юуны өмнө компани танилцуулбал, АНД Глобал нь одоогоос 4 жилийн өмнө үүсгэн байгуулагдсан технологийн компани юм. Бидний зорилго бол дэлхийн тавцанд Монгол хүний үнэлэмжийг дээшлүүлж, хүлээн зөвшөөрүүлэх, мөн түүнчлэн Монголчууд бид хамтраад нэгдсэн зорилгын төлөө тууштай зүтгэвэл ямар амжилтад хүрч болдгийг нотлон харуулах юм.

Манай компанийн хувьд одоогоор дэлхийн 10 гаруй улсад үйл ажиллагаагаа тэлж технологи, бизнесийн нөү-хау зэргээ экспортлохоор ажиллаж байгаа бөгөөд Монгол болон Филиппин улсад мөн В2С буюу бүтээгдэхүүн үйлчилгээгээ шууд эцсийн хэрэглэгчдэд хүргэдэг финтекийн бизнесийг эрхэлдэг юм.

Миний хувьд гэвэл Япон улсад банкны салбарт ажиллаж байсан туршлагатай, тэр дундаа Швейцарын хөрөнгө оруулалтын банк UBS

болон Японы 3 мега банкны нэг болох Мизухо банк зэрэг газруудад ажиллаж байгаад 2018 оноос АНД Глобал компанийнхаа зорилго, алсын хараанд хүчтэй татагдаж нутагтаа буцаж ирээд ажиллаж байна.

Анд Глобал Японы Марубени корпораций 10.3 сая ам долларын хөрөнгө оруулалтын гэрээ болон стратегийн түншлэлийн гэрээг амжилттай байгуулсан. Гэрээ байгуулах хэлэлцээр хэр хугацаанд үргэлжилсэн бэ? Мөн гэрээний хүрээнд хоёр талын хэрэгжүүлэх хамтын ажиллагааны талаар бидэнтэй хуваалцана уу?

Таны хэлсэнчлэн бид Series A буюу бизнесээ тэлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтынхаа нэг хэсэг болгож Японы Марубени корпораци болон Америкийн Текстарс компаниудаас нийтдээ 10.3 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг татаад байна. Энэ хөрөнгө оруулалт нь АНД Глобал компани дэлхийн хэмжээний компани болох замналд өндөр ач холбогдолтой, биднийг зорилгодоо хүрэх явцыг түргэсгэсэн хөрөнгө оруулалт боллоо.

Ялангуяа бидний Марубени корпораций байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээ болон Хөрөнгө оруулалтын гэрээ нь манайх шиг харьцангуй залуу Монгол стартап компанийн хувьд 160 жил үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа Японы том корпораций мөр зэрэгцэн хамтарч дэлхийд амжилт үзүүлэх нөхцөлийг үүсгэж байгаа юм. Мөн хоёр компанийн түншлэл нь хоёр улсын харилцаанд ч бас чамгүй ахицыг үзүүлэхэд нөлөөлөх болов уу гэж найдаж байна.

АНД Глобал, Марубени корпорацийн хоорондын харилцаа нь 2018 оноос эхлэлтэй бөгөөд түүнээс хойш хоёр жил хагасын хугацаанд бид харилцан бизнес, үнэт зүйлс болон багуудтайгаа танилцаж, үргэлжлүүлэн үнэлгээ, дүгнэлт, гэрээлэх үйл явцуудаа явуулсан гэж ойлгож болно. Түншлэлийн хувьд гэвэл гол чиглэл нь АНД Глобалын технологи болон Марубени корпорацийн дэлхий даяарх сүлжээг хослуулан технологийн цогц шийдлийг дэлхийд түгээх, түүнчлэн Монгол болон Филиппин улсуудад финтекийг хамтран хөгжүүлж, дараа дараачийн шатанд гаргахад оршино.

Таны бодлоор Марубени корпорацийн Анд Глобал-ыг сонгож, хөрөнгө оруулахаар болсон шалтгаан, өөрөөр хэлбэл танай баг хамт олны энэхүү хөрөнгө оруулалтыг амжилттай татаж чадсан амжилтын нууц нь юу байсан бэ?

Бидний хооронд зөвхөн хөрөнгө оруулалтад суурилсан харилцаа гэхээс илүүтэйгээр бие биедээ стратегийн ач холбогдол бүхий үнэт зүйлсийг санал болгож, нэг ёсондоо хоёр компани нэгнээ нөхөн хамтарч ажиллах стратегийн түншлэлийн харилцаа бас үүссэн нь хамтын ажиллагааг баталгаажуулж, цаашид амжилттай болох үндэс болсон болов уу. Товчхондоо бол АНД Глобал нь

залуу баг хамт олон, шинэлэг сэтгэлгээ, хурдан шаламгай байдлаа ашиглан бүтээж, амжилттайгаар зах зээлд гаргаад буй шинэлэг технологи, тэдгээрээ нэвтрүүлсэн бизнесийн нөү-хау зэргээ Марубени корпорацийт хуваалцаж, нөгөө талаас Марубени корпораци өөрсдийн олон улсын төвшний нэр хүнд, түүнд нь үзүүлэх зах зээлийн итгэл үнэмшил, он удаан жилийн туршид хуримтлуулсан бизнесийн туршлагаа бидэнтэй хуваалцаж байгаа гэсэн үг.

Яг хөрөнгө оруулалтын хувьд гэвэл мэдээж манай компани хөрөнгө оруулалт авахын тулд бизнес, санхүү, татвар, хууль журам, технологи, аюулгүй байдал гэх мэт олон талын өндөр шаардлагуудыг хангах нөхцөлтэй байсан. Маш олон шаардлагууд байсан ч бидний өнөөг хүртэл үнэн зөвөөр, ёс зүйтэйгээр, мөн алсын хараатайгаар бүх зүйлээ ном журмын дагуу бэлтгэж гүйцэтгэж ирсэн маань шалгууруудыг амжилттай давахад маш том тус болсон гэж бодож байна.

Анд Глобал Филиппин улсын зах зээлд нэвтэрсэн байгаа. Та бидэнд тус улс дахь үйл ажиллагааныхаа талаар товч танилцуулна уу? Мөн өөр улсын зээлд нэвтэрч дэлхийн зах зээл дээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх, үүнтэй холбогдуулан нэмж хөрөнгө оруулалт татах төлөвлөгөө бий юу?

Бид анх 2018 онд өөрсдийн технологид суурилсан бүтээгдэхүүнээ Филиппин улсын зах зээлд нэвтрүүлсэн ба Филиппин улс, түүнчлэн Зүүн өмнөд азид тулгамддаг underserved and underbanked буюу санхүүгийн үйлчилгээ авч чаддаггүй зуу, зуун сая хүмүүст технологийн дэвшилтэт шийдлээр санхүүгийн үйлчилгээ хүргэх боломжийг эрэлхийлж анх тухайн улсад үйл ажиллагаагаа эхлүүлсэн юм.

Бидний тэр үеэс баримталж ирсэн зорилго одоо манай Филиппин дэх бизнест хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүнээр дамжин хэрэглэгчдэд маань хүрч байна. Тухайлбал бид 7-Eleven, Weer зэрэг түнш байгууллагуудтайгаа хамтран өдөр тутмын хүнсний хэрэглээ, нийтийн тээврээр зорчих хэрэгцээ зэргийг санхүүгийн ерөнхий үйлчилгээтэй нь хамт хэрэглэгчдэдээ санал болгож байна.

Энэ бол бидний хувьд зөвхөн эхлэл бөгөөд бид цаашдаа дээр дурдсан санхүүгийн наад захын үйлчилгээг авах боломжгүй байдаг хүмүүсийг хамарсан цахим экосистемийг бүрдүүлэхээр Марубени корпораци болон тун удахгүй бидний стратегийн түнш болох бас нэгэн Японы томоохон финтекийн конгломерат компанитай төлөвлөөд явж байна.

Бусад улс болон дэлхийн зах зээл дэх бизнесийн төлөвлөгөө гэвэл бид өөрсдийн бүтээсэн технологийн шийдлүүдээ олон улсад нийлүүлэх замаар үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна. Яг өнөөдрийн



байдлаар гэхэд Япон, Солонгос, Сингапур, Индонез, Хонг Конг, Камбож, Малайз, Филиппин гэх мэт 10 гаруй улсад тус төлөвлөгөөнийхөө дагуу хэлэлцээрүүд хийж байгаа.

Ийм арга барилаар дэлхийн зах зээл дэх үйл ажиллагаагаа улам далайцтай өргөжүүлэх, улам шинэлэг, дэвшилтэт технологийг бүтээн нийлүүлэх үүднээс дээр дурдсанчлан Японы бас нэгэн финтекийн том конгломераттай стратегийн түншлэл үүсгэн хөрөнгө оруулалт татахаар ажил маань ид өрнөж байна. Энэ талаараа та бүхэндээ удахгүй нээлттэй зарлах боломжтой болох байх гэж найдаж байна.

Гарааны бизнес эрхлэгчид зөв хөрөнгө оруулагчаа олж, хөрөнгө оруулалт татахад юун дээр түлхүү анхаарах шаардлагатай вэ? Та өөрийн туршлагаас хуваалцвал?

Зөв хөрөнгө оруулагчаа олж сонгох нь хөрөнгө оруулалт татахын хамгийн чухал хэсгийн нэг гэж боддог. Гол нь аль нь “зөв хөрөнгө оруулагч” вэ гэдэг нь өөрөө тухайн бизнес маань ямар зорилгоор хөрөнгө босгож байгаа, хоёр талын хоорондын нийлэмж хэр вэ гэх зэргээс их хамаарна.

Манай компанийн хувьд алсын хараа, зорилгодоо нийцэх хамтрагч хайж байсан бол Марубени корпорац дэлхийд шинэлэг технологийн шийдэл нийлүүлэх технологийн түнш хайж байсан гээд давхцалууд олон байсан. Бидний зүгээс хөрөнгө оруулагчдаа тавьж байсан гол шаардлага бол АНД Глобалын алсын хараа, үнэт зүйлсийг хүндэтгэж, тэдгээрт нь итгэж, хамтдаа тэмүүлэх эрмэлзэлтэй байх гэдэг байсан ба үүнийг маань Марубени корпорац биелүүлж чадна гэдэгт бид итгэсэн учраас түншлэл маань эхэлсэн. Шулуухан хуваалцахад бид Марубени корпорацаас өмнө хэд хэдэн хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулалтын санал авч байсан ч тухай бүрдээ миний сая дурдсан шалгуур буюу компанийн маань алсын хараа, үнэт зүйлсийг ойлгож, хамтран ажиллаж чадахгүй юм байна гэх шалгаанаар татгалзаж байлаа.

Гадаадын хөрөнгө оруулалтын статистик тоо мэдээллээс харахад Япон улсаас Монгол Улсын технологийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ бусад салбаруудтай харьцуулахад харьцангуй бага хувийг эзэлдэг. Монголд энэ салбарын гарааны бизнест хөрөнгө оруулалт босгох, хоёр улсын технологийн салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж хэр байна вэ?

Миний харж байгаагаар манай улсын технологийн салбарт чанартай, цаг үеэ олсон бүтээгдэхүүн үйлчилгээг дэлхийн стандартаар бүтээж байгаа гарааны бизнесүүд чамгүй олон байгаагаар барахгүй зөв хамтрагчаа олж чадвал хөрөнгө оруулалт татах, хамтын ажиллагаа үүсгэх зэрэг боломжууд нээлттэй байгаа гэж бодож байна. Япон хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн нэг онцлог бол түншлэх компани болон бизнесийн хамтрагч болох хүмүүсээ танихад маш их цаг, эрч хүч зарцуулах хандлагатай байдаг санагддаг. Гарааны бизнесүүдийн хувьд энэ үйл явц нь сэтгэл санааны болон бизнесийн нөөц бололцооны хувьд хүлээхэд хэцүү нөхцөл байдлыг үүсгэдэг тал бий. Гэхдээ тухайн бизнесийн маань нөөц бололцоо энэхүү хугацааг даван туулах боломжтой гэж үзсэн тохиолдолд зөв хөрөнгө оруулагчтай хамтрахын тулд тэвчээртэй, тууштай зүтгээсэй гэж хүсдэг.

Нөгөө талаас манай улс шинэ технологи, бизнесээ туршиж, цааш нь гаднын улсуудад нийлүүлэхэд тохиромжтой зах зээл гэж боддог, үүгээрээ Сингапур улстай төстэй. Үүний нэг тод жишээ гэвэл Японы KDDI компани бөгөөд тус компани нь Монголын Мобиком корпорацын бизнес, технологийн нөү-хау зэргээ Мьянмар улсад амжилттай хэрэгжүүлж, олон улс дахь бизнесээ өргөжүүлсэн туршлагатай. Үүнээс харахад дотоодын гарааны бизнесүүдийн хувьд манай улсын зах зээл хэдий жижиг боловч хамтын ажиллагаа үүсгэх, хөрөнгө оруулалт татахад тааламжтай нөхцөлүүдийг бүрдүүлсэн онцлогтой гэдгийг нь дурдах нь зүйтэй байх.

Ярилцлагынхаа төгсгөлд Анд Глобал-ын цаашдын зорилго, хийхээр зорьж буй өөрчлөлтүүдийн талаар бидэнтэй хуваалцаж,

гадаадын хөрөнгө оруулалт татах чиглэлд төр ба хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааны боломжийн талаар өөрийн зүгээс санал бодлоо илэрхийлэхгүй юу?

Бид алсын хараа, зорилгодоо хүрэхийн төлөө олон улсын бизнесээ улам далайцтайгаар өргөжүүлэхэд төвлөрөн ажиллаж байна. Мөн энэ хүрээнд дээр дурдсан Японы бас нэгэн финтекийн томоохон конгломераттай хамтын ажиллагаагаа эхлүүлэн, хөрөнгө оруулалт татах ажил маань ид төгсгөлийн шатандаа явж байна.

Хувьдаа дүгнэхэд манай компанийн өнөөдрийг хүртэл бүтээсэн нэгэн үнэт зүйл нь эдгээр дэлхийд гарах гарц болсон түншлэлүүд маань яалт ч үгүй мөн. Олон Монгол гарааны бизнес дэлхийн тавцанд өрсөлдөөсэй гэж хүсдэг учраас бид энэхүү үнэт зүйлээ салбарынхаа бусад гарааны бизнесүүдтэй хуваалцаж хамтран зүтгэхээр бас ажиллаж байна. Энэ ажил маань түрүүчээсээ эхлээд уулзалт, хэлэлцээрүүд маань өрнөж байгаа ба энэ дашрамд дэлхийд өөрсдийн бүтээсэн технологиороо өрсөлдье гэсэн хүсэл эрмэлзэлтэй, түүнийхээ төлөө тууштай тэмцэхэд бэлэн гарааны бизнесүүд байвал бидэнтэй чөлөөтэй холбогдоорой гэж уриалъя.

Гадаадаас хөрөнгө оруулалт татах чиглэл дээр төрөөс хувь нэмрээ оруулаасай гэж боддог хамгийн том зүйл бол гадаадын хөрөнгө оруулагчдад итгэл үнэмшил төрүүлэх явдал юм. Миний хувьд өдийг хүртэл гадаадын хөрөнгө оруулалт татахаар олон улсын олон ч хөрөнгө оруулагчидтай уулзаж байхад хамгийн их тулгарч байсан нэг асуудал бол Монголоос гаралтай гарааны бизнест итгэх итгэл маш муу, бараг байхгүй гэхэд хилсдэхгүй. Тийм ч учраас төрийн зүгээс гадаадын хөрөнгө оруулагчидтай холбож өгөх, уулзалт зохион байгуулах, гадаадын айлчлал, уулзалтад хувийн хэвшлийн төлөөллийг хамруулах гэх зэргээр хамтран ажиллавал хөрөнгө оруулагчдад итгэл үнэмшил төрүүлээд зогсохгүй хувийн хэвшлийн үйл ажиллагаанд маш том нэмэр болно гэж бодож байна.

Цаг зав гарган “Амжилтын түүх”-ээ бидэнтэй хуваалцсанд маш их баярлалаа. Танд болон танай баг хамт олонд цаашид хэрэгжүүлэх том төслүүдэд нь амжилт хүсье.



Ярилцлагыг хийж бэлтгэсэн ҮХГ-ын Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Г.МӨНХТУЯА

“長期ビジョン2050” モンゴル国長期開発計画

“АЛСЫН ХАРАА - 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БА ЯПОН УЛСТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Аливаа улсын хөгжлийн бодлого нь тухайн улсын хөгжлийн философийн хүрээнд нэгдмэл цогц, залгамж чанарыг агуулсан, түүнд салбар хоорондын болон аймаг /бүс, муж/ хоорондын хөгжлийн асуудлыг уялдуулж ажлын байрыг ихээр нэмэгдүүлэх эдийн засгийн бүтцийг бий болгох, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бий болгох ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, ардчилал, иргэдийн үндсэн эрхээ хэрэгжүүлэх эрхзүйн орчин, засаглалыг бий болгох, дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх боломжтой байхаар боловсруулсан баримт бичиг юм.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сард Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Уг нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлана, мөн хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж тус тус заасан. Улмаар Үндсэн хуулийн энэхүү нэмэлт, өөрчлөлтөд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх хэрэгцээ, шаардлагын улмаас Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 5 дугаар сард УИХ-аар баталсан.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хангах хуулиуд батлагдсанаар Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам, аргачлал, арга зүй сайжирч, шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаанд суурилсан бодлого батлах таатай нөхцөл бүрдэж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн уялдаа бий болсноор улс, орон нутгийн төсвийн, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд амжилттай хэрэгжих ач холбогдолтой юм.

Монгол Улс хүний хөгжлийн үзүүлэлтээр дэлхийн 177 орноос 92, эдийн засгийн

өрсөлдөх чадварын индексээр дэлхийн 140 орноос 99, бизнес орчны индексээр 190 орноос 74, авлигын индексээр 93 дугаар байрт жагсаж байна. Тодруулбал, Монгол Улс хөгжлийн олон үзүүлэлтээр бүс нутгийн улс орнууд, дэлхийн дунджаас доогуур түвшинд байгаа юм.

Тиймээс өнгөрсөн 30 жилийг бүхэлд нь дүгнэж, ирэх 30 жилийн хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нь зөв хэмээн Засгийн газар үзэж, дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго-2030” баримт бичигтэй нийцүүлэн “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталсан.

“Алсын хараа-2050” нь Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван, аюулгүй нийгэм, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн 9 бүлэг, 47 зорилттой бөгөөд 10 жилээр буюу 2021-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн 3 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүний эхлэл болгож Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, үүний хавсралт баримт бичиг болох Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг батлаад байна.

Уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийн тогтолцоог өөрчилж, хувийн хэвшлийн идэвхтэй оролцоотойгоор аж үйлдвэрийн салбарыг төрөлжүүлэх зорилгыг дэмжиж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээ, Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилтуудыг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа маш чухал юм.



Монгол Улсаас Япон Улсад суугаа
Элчин сайдын яамны Зөвлөх бөгөөд
Худалдаа, эдийн засгийн хэлтсийн дарга

Б.БАЯРСАЙХАН (PH.D.)

Үүнд эдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд Монгол Улс, Япон улс хооронд байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд хоёр улсын хамтын ажиллагааг эрчимжүүлж, амжилттай хэрэгжүүлэх нь чухал юм.

Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь хоёр орны хөрөнгө оруулалт, бараа бүтээгдэхүүний урсгал, цаашлаад иргэд хоорондын харилцаа холбоог нэмэгдүүлж, хувийн хэвшлийнхэнд бизнесээ тэлэх, хөрөнгө оруулалт хийх шинэ боломжийг бүрдүүлж, улмаар хоёр орны эдийн засгийн харилцааг бие биеэ нөхөх шинэ шатанд гаргана.

Тиймээс энэхүү хэлэлцээрийг амжилттай хэрэгжүүлэхэд Монгол, Япон бизнес эрхлэгчид хоёр орны нөхцөл байдлыг харилцан мэдэх нь чухал юм. Үүнтэй холбогдуулан хоёр улсын үндэсний хэмжээнд төдийгүй бүс нутгуудын хүрээнд хамтран ажиллах боломжтой чиглэл, салбараас жишээ болгон дурдвал:

ДЭД БҮТЭЦ:

Далайд гарцгүй Монгол орны хувьд арлын Япон Улстай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц нь агаарын тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц юм. Агаарын тээвэр бол



SUSTAINABLE
DEVELOPMENT
GOALS



長期ビジョン2050：政策実施段階

モンゴル国長期開発政策“長期ビジョン2050”9つ基本理念、47つ目標ごとに基本方針を定めている。



第三段階

2041-2050

第二段階

2031-2040

第一段階

2021-2030

Япон Улстай шууд харилцах хамгийн чухал дэд бүтцийн нэг бөгөөд шинэ нисэх онгоцны буудлын төслийг Япон улсын хөнгөлөлттэй зээлээр байгуулан менежментийг нь концессоор хөгжүүлэх япон, монголын хамтарсан төсөл хэрэгжиж байна. Хөшигийн хөндийн шинэ нисэх буудлыг түшиглэн эдийн засаг, худалдааны хамтарсан чөлөөт бүс байгуулах замаар хоёр орны эдийн засгийн түншлэлийг гүнзгийрүүлэх боломж бүрдэж байна.

Мөн хоёр орны хооронд мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх замаар мэдээллийн технологи, инновацын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж бүрдэнэ.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ:

Энэ салбарын хүчин чадлыг нэмэгдүүлэх, улирлын хамаарлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай. Японы жуулчдыг Монголын бүс нутгуудад татахын тулд тусгайлсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй.

Энэ хүрээнд Японы жуулчинд үзүүлэх үйлчилгээний чанар стандартыг бий болгох, дэд бүтцийг хөгжүүлэхэд Япон Улсын аялал жуулчлалын томоохон компани, корпорацитай харилцан ашигтай хамтран ажиллах механизмыг бүрдүүлж чадвал илүү үр дүнд хүрэх боломжтой гэж үзэж байна.

БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР:

Ноос, ноолуурын салбарыг жишээ болгон авч үзвэл Монгол Улс дэлхийн түүхий ноолуурын 45 хувийг бэлтгэдэг боловч ноолууран бүтээгдэхүүний зах зээлд дөнгөж 2 хувьтай байна.

Түүхий ноолуур бэлтгэн нийлүүлэх, угаах, самнах утас ээрэх, сүлжих, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд борлуулах нийлүүлэлтийн хэлхээнд утас ээрэх, сүлжих, даавуу боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэсэгт нийт 300 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд уг төсөл нь 13 мянган ажлын байр бий болж, Япон Улсад экспортлох хэмжээг эрс нэмэгдсэнээр хоёр орны Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрээр худалдааны тэнцэл сайжрахад дэмжлэг болно.

ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Чөлөөт худалдааны хэлэлцээр (EPA) байгуулснаас хойш хоёр орны худалдааны хэмжээ нэмэгдсэн боловч манай улсын хувьд худалдааны алдагдал нэмэгдсэн. Монгол Улсад хамтарсан төсөл хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэл хөгжүүлэн Япон болон гуравдагч зах зээлд бүтээгдэхүүн борлуулах замаар худалдааны алдагдлыг бууруулж, хоёр орны эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Манай улсын нийт экспортын 88.4 хувийг уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн бүрдүүлж байна. Тиймээс эдийн засгийг солонгоруулж, худалдааны тэнцлийг сайжруулах чиглэлээр ХАА, ойн аж ахуй, аж үйлдвэрлэл, ЖДҮ, барилга, хот байгуулалт, шинжлэх ухаан, технологи, санхүүгийн үйлчилгээ, боловсрол, хүний нөөцийн хөгжил, байгаль орчин, мэдээлэл, харилцаа холбооны технологи болон хоёр улсын Засгийн газар хооронд харилцан тохиролцсон бусад салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх нь зүйтэй.

Төгсгөлд нь хэлэхэд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх эрхзүйн орчин бүрдсэн тул Монгол Улсын Засгийн газрын бүтэц өөрчлөгдөх, дүрэм журам амархан өөрчлөгдөх зэргээс болж Монгол Улсад бизнес эрхлэхэд Японы бизнес эрхлэгчдэд тулгардаг байсан бэрхшээлүүд арилж, илүү таатай, тогтвортой орчин бүрдэнэ гэж үзэж байна. Хоёр улсын хамтын ажиллагааг илүү эрчимтэй хөгжүүлэх нөөц боломжтой байгаа бөгөөд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь Япон, Монгол Улсын олон талт харилцааг хөгжүүлэхэд эдийн засгийн нягт харилцаа, томоохон гүүр болно гэдэгт итгэж байна.

Цаашид Монгол Улсын элчин сайдын яамнаас YXF-тай хамтран япон хэл дээр энэхүү мэдээллийн товхимлыг сар тутам хамтран гаргах ба та бүхэнд Монгол Улсын хөгжлийн “Алсын хараа 2050”-ийн 9 тулгуур зорилго, 47 зорилтын талаар нэг бүрчлэн тайлбарлан цуврал нийтлэлийг хүргүүлж, мөн Япон улстай хамтын ажиллагааны талаар илүү нарийн тодорхой салбаруудын талаар цуврал мэдээлэл танилцуулах болно.

Мөн дэлгэрэнгүй мэдээлэл, төсөл хөтөлбөрүүдийн талаар та бүхэн миний Япон Улсын Эдийн засаг, худалдаа, үйлдвэрлэлийн судалгааны хүрээлэнгээс 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр зохион байгуулсан вебинарт танилцуулсан дараах илтгэлээс үзнэ үү.

<https://www.rieti.go.jp/jp/events/21040701/handout.html>

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТСАНААР МОНГОЛ УЛС ЭРЧИМ ХҮЧИЙГ ЭКСПОРТЛОХ БҮРЭН БОЛОМЖТОЙ УЛС БОЛНО



Эрчим хүчний зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтсийн захирал

Л.ЖАМБАА



Ньюком группын ТУЗ-ын гишүүн

Э.ОРЧЛОН

Сайн байна уу та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе, Үндэсний хөгжлийн газраас хөрөнгө оруулагчдад зориулан сар бүр эрхлэн гаргадаг товхимлын онцлох ярилцлага буланд оролцох урилгыг хүлээн авсан Эрчим хүчний зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтсийн захирал Л.Жамбаа болон “Ньюком” группын ТУЗ-ын гишүүн Э.Орчлон нарт маш их талархлаа. Өнөөдрийн манай дугаар маш онцлог болж байна учир нь гэвэл Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний нөөц, боломж, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, тариф, зохицуулалтын талаас төрийн төлөөлөл мөн сэргээгдэх эрчим хүчний салбарт анх удаа хөрөнгө оруулалт татаж, төслийг амжилттай хийж гүйцэтгэсэн хувийн хэвшлийн төлөөллөөс оролцож байгаа юм

Монгол Улсын эрчим хүчний өнөөгийн нөхцөл байдал, хэрэглээ, хэрэгцээ, цаашдын хөгжилд Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь, хэмжээ ямар байгаа талаар бидэнтэй хуваалцана уу?

Л.ЖАМБАА: Сайн байна уу, Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Эрчим хүчний салбарын өнөөгийн бүх нөхцөл байдлын талаар та бүхэндээ нээлттэй ярилцъя гэж бодож байна. Энэхүү салбарт цахилгаан, дулаан, хийг Монгол Улсын эрчим хуулиар эрчим хүч гэж ойлгож байгаа ч үүн дотор мөн сэргээгдэх эрчим хүч ороод явдаг. 2020 оны жилийн эцсийн статистик мэдээллээр Монгол Улс нийтдээ 80.7 хувийн эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэж байна, харин үлдсэн 19.3 хувийг импортын цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Цахилгаан эрчим хүчний импорт, экспорт дэлхийн олон орон байдаг түгээмэл үзэгдэл бөгөөд эрчим хүчний системийн найдвартай ажиллагаанд чухал ач холбогдолтой байдаг.

Манай улсын хувьд экспорт импорт харьцаа алдагдсан, хэрэглээнийхээ 20 орчим хувийг импортлож байна гэдэг маань эрчим хүчний аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй нөхцөлд байгааг харуулж байгаа юм. Ялангуяа оройн цагаар 7-10 цагийн хооронд ид ачаалалтай үедээ дээрх хорин хувийн эрчим хүчээ богино хугацаанд ОХУ-аас цахилгаан эрчим хүч худалдаж авч байна. Өмнөд хөршөөс Оюутолгойн цахилгаан эрчим хүчийг Өвөрмонголоос авдаг ийм үзүүлэлттэй байна. Цаашдаа бид хөрш улсуудынхаа эрчим хүчний системтэй холбоотой байж, гэхдээ одоогийн импортын цахилгаан эрчим хүчний тоо хэмжээг бууруулъя гэсэн зорилт тавиад ажиллаж байна.

Монгол Улсын хувьд мөн эрчим хүчний системийн хувьд эрчим хүч, цахилгааны хараат байдал нь эрсдэлд оруулах тул бид дотооддоо эрчим хүч, цахилгаанаа бүрэн хангадаг мөн аюулгүй байдлаа хангах үүднээс 20 хувьтай тэнцэх бэлэн нөөцтэй байх хэрэгтэй байна. Түүнчлэн богино хугацаанд дотооддоо эрчим хүчээ бүрэн хангаж, урт хугацаандаа эрчим хүч, цахилгааныг экспортолно гэсэн зорилт зорилгуудыг тавиад ажиллаж байна.

Эрчим хүчний салбарт хийсэн томоохон бүтээн байгуулалт болох Салхит салхин цахилгаан станц, Цэцийн салхин цахилгаан станц төслийг ямар суурь шалтгаан үндэслэлээр барьж байгуулах болсон бэ? Монгол Улсын хувьд сэргээгдэх эрчим хүчний нөөц болон салхины хурд ямар түвшинд байдаг вэ?

Э.ОРЧЛОН: Сайн байна уу, Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе, энэхүү дугаарын онцлох буланд урьж оролцуулсанд баярлалаа. “Ньюком” группийн хувьд сэргээгдэх эрчим хүчний салбарт хамгийн анхны хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар цахилгаан станцын бүтээн байгуулалтуудыг хийсэн ба Монгол Улсын хамгийн анхны сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх салхины “Салхит цахилгаан станц”-ыг 2013 онд ашиглалтад оруулж байсан бөгөөд одоо хүртэл найм гаруй жил үйл ажиллагаагаа тасралтгүй хангаад явж байна.

Энэхүү бүтээн байгуулалтыг дагаад сэргээгдэх эрчим хүчний салбарт дараа дараагийн хөрөнгө оруулалтын үүд хаалга, боломж манай улсын хувьд нээгдсэн гэж хэлж болно. 2017 онд хоёр дахь төсөл болох 50МВ-ийн Салхин станцын паркийг Цогтцэцийн Сэрс суманд ашиглалтад оруулсан. Уг хоёр төслийн өртөг тус бүр нь 128 сая ам.доллар буюу нийт 256 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг өөрийн эх үүсвэр болон гаднын эх үүсвэрүүдээс амжилттай татаж чадсан.

Ирээдүйд бид Монгол Улсаас жилд Азийн эрчим хүчний хэрэглээг хангах төдий чинээ их нар, салхины нөөц байгаа бөгөөд бид энэ нөөцөө ашиглаад уул уурхайн салбар шиг сэргээгдэх эрчим хүчний салбарыг БНХАУ, БНСУ, Япон руу экспортлох асар том боломж байна гэж харж байна. Үүний төлөө бид нар, салхины асар их судалгаа, шинжилгээ хийж, ТЭЗҮ, ТЭЗҮ Судалгаанд оролцоод явж байна. Бид 10 жилийн турш салхины болон нөөцийн судалгааг хийсэн, хаана салхин цахилгаан станц барихад салхины хурд өндөр байх вэ?, хамгийн сайн салхитай газар хаана байна?, тэр газраасаа шугам татахад өртөг нь хэр байх вэ?, цахилгаан шингээх чадвар хэр зэрэг байх вэ? гэх мэт судалгаанд дээр үндэслэгдэж энэхүү төслүүд маань хэрэгжээд явдаг.

Өнөөдрийн байдлаар Азийн супер сүлжээ төслийн ТЭЗҮ нь хийгдээд дуусч байна үүнд 2051 он гэхэд энэ салбарт 57 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх боломжтой ба Говьд эх үүсвэрүүдийг нь бий болгоод Монголоос шугам татаж БНХАУ, БНСУ, Япон руу цахилгаан нийлүүлэх эрэлт, хэрэгцээ байгаа тул хэзээ хийх вэ гэдэг нь цаг хугацааны асуудал болоод байна. Дээрх дурдсан улсуудад цахилгаан болон датаны ихээхэн хэмжээний хэрэгцээ байгаа боловч дотооддоо эрчим хүчний хэрэглээгээ хангаж чадахгүй байгаа нь Монгол Улс болон Өвөрмонголоос эрчим хүч авах бүрэн боломж нээгдэж байгаа юм.

Мөн энэхүү өндөр өртөг бүхий төслийг хэрэгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрхэн, хаанаас татаж байсан бэ? Анхны хөрөнгө оруулалтаар амжилттай хийгдсэн бүтээн байгуулалт учир ямар хүндрэл бэрхшээл, ололт амжилт гарч байсан бэ?

Э.ОРЧЛОН: 2013 оноос өмнө сэргээгдэх эрчим хүчний салбарт хувийн хэвшил хөрөнгө босгоод цахилгаан станцын бүтээн байгуулалт хийж, эрчим хүч нийлүүлнэ гэдэг ойлголт нь хомстолтой байсан бөгөөд цахилгаан, дулааныг улсаас шийдвэрлэнэ гэж ойлгогддог байсан. Хувийн хэвшил хөрөнгө оруулалт татаад, бүтээн байгуулалт хийж болох уу гэдэг ойлголт дээр эрх зүйн орчин болон ард иргэд, хүмүүсийн сэтгэл санааны байдал нь бидний хувьд хамгийн эхний том сорилт болж байсан.

Бид энэхүү ажлыг эхлүүлэхдээ маш их хэмжээний суурь судалгааг олон жилийн туршид хийж өөрсдийн нөөц, боломж, хэрэгцээ дээрээ тулгуурлаж олон улсын байгууллага, банк санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалт болон зээлийг татах байдлаар хамтарч ажилласан. Үүнийг бид төрөөс бодлого боловсруулж, зохицуулж буй хүмүүстэй хамтран ойлголцож чадсан үндэс суурь нь "Эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулах байсан юм. Нэг талаас төр болон нөгөө талаас хувийн хэвшил хөрөнгө оруулсан ЖАЙКА, ЕСБХБ ороод явна гэсэн үг.

Үүнд бид улсын төсвөөс санхүүжилт авахгүй, төсөвт нэмэлт дарамт үзүүлэхгүйгээр өөрсдөө 128 сая ам.долларыг санхүүжилтийг босгоод, эрсдэлээ хариуцаад ийм хэмжээний цахилгаан станц барьж байгууллаа гээд төрөөс асуудаг үүн дээр Эрчим хүчний яам холбогдох байгууллагаас шалгаж судалгаа, тооцооллыг хийснээр эрчим хүчийг дотоодоосоо хангах нь зөв гэдэг дүгнэлт дээр үндэслэн нэг ёсны хувийн хэвшилээс цахилгаан станц баривал төр эрчим хүч худалдаж авна гэсэн гэрээ юм.

Мөн дутуу барих, барьсан цахилгаан станцын салхины хурд хүрэхгүй байх гэх мэт эрсдэлүүдийг бид өөрсдөө бүрэн хариуцаж явдаг ба энэхүү бүтээн байгуулалт хийгдэж, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх юм бол төрөөс худалдаж авна гэдэг ойлголцлын дагуу энэхүү гэрээ нь хийгдэж байгаа юм.

Уг гэрээг хийсний үндсэн дээр бид хөрөнгө татах, босгох ажил хийгдээд явдаг бөгөөд гэрээний тогтвортой, хөдөлшгүй байдал нь суурь үндэс болж өгдөг юм. Хугацааны хувьд 20 жилээр хийгддэг учир нь гэвэл эрчим хүчний салбарт асар их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай нөгөө талаас хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа нь их удаан явагддаг. Энэ салбарт тогтвортой, хүлээцтэй, урт хугацааны хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулах салбар юм.

Монгол Улсад нийтдээ эрчим хүчний салбарт хэдий хэр хэмжээний хөрөнгө оруулалт хийгдсэн статистик үзүүлэлт байгаа вэ? Цаашид мөн хөрөнгө оруулалтын өсөлтийг хэрхэн харж байгаа вэ?

Л.ЖАМБАА: Эрчим хүчний зохицуулах хорооноос жил бүр эрчим хүчний компаниудын тариф батлахдаа тухайн жилд хийгдэх шаардлагатай засвар угсралт, компанийн хэмжээний хөрөнгө оруулалтын хэмжээг тусгаж өгдөг. Хөрөнгө оруулалтын хувьд томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийдэг жишиг байгаа. Мөн Олон Улсын байгууллагууд /Дэлхийн банк (ДБ), Азийн хөгжлийн банк(АХБ), Европын сэргэн босголт хөгжлийн банк(ЕСБХБ)/ сүүлийн үед эрчим хүч тэр дундаа сэргээгдэх эрчим хүчний салбарт ихээхэн хөрөнгө оруулалт хийж байна. Хамгийн сүүлийн жишээ бол Баруун аймгуудад нийтдээ 45МВ-ын нар, салхи, эрчим хүч хуримтлуурын цахилгаан станцын төслийг ДБ, АХБ хамтран хэрэгжүүлж байна.

Дэлхийн Банкны хийсэн эрчим хүчний мастер төлөвлөгөөний судалгаанаас харахад ойролцоогоор 2030 он гэхэд 4-5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт эрчим хүчний салбарт хийгдэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд санхүүгийн эх үүсвэр нь шийдэгдээгүй байгаа нар болон салхины станцууд, усан цахилгаан станц, нүүрсний цахилгаан станцын өргөтгөл, шугам сүлжээ, тоног төхөөрөмж сайжруулах гээд орсон байгаа юм. Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хийх хөрөнгө оруулалтын хэмжээ нь өндөр хувьтай байхаар харагдаж байгаа нь хүлэмжийн хийг бууруулах Монгол улсын зорилттой холбоотой юм.

Манай улсын эрчим хүчний салбар нь улсын хүлэмжийн ялгарлын талаас илүү хувийг дангаараа бий болгодог тул хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах томоохон арга хэмжээнүүдийг энэ салбарт зайлшгүй хийх шаардлагатай байна. Монгол Улсын хүлэмжийн хийг бууруулах үндэсний тодорхойлох хувь нэмэр баримт бичгийг шинэчлэн боловсруулаад НҮБ-д хүргүүлсэн байгаа. 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 2010 онтой харьцуулахад 22.7 хувь бууруулна гэсэн зорилт тавьсны бөгөөд үүнийг сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих замаар уг зорилтод хүрэх юм. Дээрх зорилтод туссан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ойролцоогоор 700 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байна.

Өнгөрсөн хугацаанд сэргээгдэх эрчим хүчний салбарт ямар хөрөнгө оруулалт хийгдсэн бэ гэвэл Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль 2007 онд батлагдаад Feed-in Tariff (FiT) дэмжих тарифыг хуулиндаа тусгаж өгсөн. Учир нь тухайн үед сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн өртөг өндөр байсан,

зайлшгүй төрөөс дэмжлэг шаардлагатай байсан. Өнөөдөр үйл ажиллагаа явуулж буй 9 том чадлын нар, салхины станцууд бүгдээрээ тэр үеийн тарифын хүрээнд хэрэгжиж байгаа. 2013 онд анхны Салхитын 50МВ салхин цахилгаан станц 100 гаруй сая ам.долларын санхүүжилттэй ашиглалтад орж байсан.

Үүнээс хойш нийтдээ 600 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт сэргээгдэх эрчим хүчний салбарт хийгдсэн байна. Цаашид сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, мөн сэргээгдэх эрчим хүч гэдэг утгаараа уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийн чиглэлээр дэмжих боломжууд бий болж байна.

Монголд энэхүү томоохон хэмжээний бүтээн байгуулалтыг хийхэд хүний нөөц, ажиллах хүчний хувьд манай улс хэр бэлтгэлтэй байсан бэ? Хэрэв гадаадын хөрөнгө оруулагч энэхүү салбарт хөрөнгө оруулахаар сонирхож байгаа бол та хандаж юу гэж хэлэх вэ?

Э.ОРЧЛОН: Энэхүү салбарт бид хараахан бүрэн бэлтгэгдээгүй байгаа хэдий ч суралцаад явж байна. Салхитын цахилгаан станцын хувьд ажиглахад гүйцэтгэгч компани нь гадаадын компани байсан ба гол гүйцэтгэгч компани нь Австралийн Лэйтон гэдэг компани байсан, мөн ихэнх шийдвэр гаргадаг инженерүүд нь гадаадын орноос байсан туршлагууд дээрээ үндэслээд Цэцийн цахилгаан станц дээр 98 хувь Монголчууд өөрсдөө ажилласан.

Цаашдаа Азийн супер сүлжээнд сэргээгдэх эрчим хүчний салбарт зайлшгүй сайн инженер, боловсон хүчин бэлтгэх шаардлагатай. Үүнд манай мэргэжлийн сургуулиуд анхаарч ажиллах ёстой ба төдий чинээ бид хамгийн өрсөлдөхүйц бүтээн байгуулалт барих нөхцөл үүснэ. Яг сэргээгдэх эрчим хүчний салбарыг харьцуулахад арай хялбар үүн дээр жишээ татахад Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт гэдэг мөн дэлхий дахинд уул уурхайн хувьд харахад асар цогц, хүнд төсөл газрын гүнд ажиллана, маш урт хоолой гэх мэт асар өндөр нарийн технологи шаардсан учир ойрын 5-10 жилд зөвхөн Монголчууд ажиллах боломжгүй бөгөөд заавал Рио Тинто шиг томоохон компанитай хамтарч бүтээн байгуулалт хийх суурь нь бий болж байна.

Харин сэргээгдэх эрчим хүчний салбарт тоног төхөөрөмж, турбиныг оруулаад ирэхэд бид өөрсдөө суурийг цутгах болон, угсралт мөн дэд станц, холбогдох шугамаа өөрсдөө барьж чадаж байна гээд энэ бүгдээс харахад сэргээгдэх эрчим хүчний салбарт мэргэшсэн хүний нөөц болох потенциал нь бүрэн байна гэж харж байна. Энэ мэдлэг, чадвараараа бусад орныг түүчээлж, туршлагаасаа хуваалцахад хүрэх боломжтой юм.

Монгол Улсын хувьд сэргээгдэх эрчим хүчний зах зээлийн эрэлт нийлүүлэлт хэрхэн хэмжээнд байгаа вэ? Энэхүү салбарын хэтийн зорилго, зорилт юу вэ?

Л.ЖАМБАА: Манай орны хувьд сэргээгдэх эрчим хүчийг 2015 онд 2020 он гэхэд нийт суурилуулсан хүчин чадлын 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүрнэ гэсэн зорилт тавиад ажиллаж байна. 2020 оны хувьд бид зорилт тавьсан 20 хувьдаа хараахан хүрээгүй байгаа ч 18.3 хувьд хүрсэн сайн үзүүлэлттэй байна. Зорилт тавьж буй 20, 30 хувь нь доод түвшин учир үүнээс ч нэмэгдэх боломжтой. Дээрх зорилт маань Сэргээгдэх эрчим хүчний хүчин чадлын хувьд 18.3 хувь байгаа бөгөөд харин түүнээс үйлдвэрлэж байгаа цахилгаан эрчим хүчний хувь 9.1 буюу аль аль нь 20 хувьдаа хүрээгүй байна гэсэн үг юм.

Цаашид сэргээгдэх эрчим хүч ямар чиглэлээр хөгжих боломжтой вэ гэвэл өнөөгийн түвшинд нэн тэргүүнд жижиг овроор айл өрх, аж ахуйн нэгжийн хэмжээнд нар, салхин, газрын гүний дулааны станцуудыг ашиглах нөөц бололцоо бүрэн байгаа мөн дээрээс нь хууль эрхзүйн орчин бүрдсэн. Харин том чадлаар барихаар бол Renewable energy competitive procurement зарчмаар төслийг сонгон шалгаруулдаг болсон. Энэ ондоо бэлтгэл ажлыг хангаад ирэх оноос томоохон хэмжээний станцын төслийг Эрчим хүчний яамнаас зарлахаар төлөвлөж байгаа талаар дуулсан. Үүн дээр гаднын хөрөнгө оруулалт шаардлагатай ба хөрөнгө оруулагчид тухайн олон улсын нээлттэй тендер оролцох бүрэн боломжтой болж байгаа юм.

Урт хугацаандаа Зүүн Хойд Азийн цахилгаан станц, эрчим хүчний нэгдсэн системд Монгол Улс санаачилгын хүрээнд оролцоод явах боломжтой. Энэ чиглэлээр Япон, БНСУ, БНХАУ-ын судлаачид тооцоолол хийгээд Монгол Улсаас 2030 он гэхэд 12 ГВт-ийн /манай орны өнөөгийн эрчим хүчний чадлаас ойролцоогоор 8 дахин их/ нар, салхины цахилгаан станц барих боломжтой юм байна гэсэн судалгаа гарсан байгаа нь цаашдаа бид экспортлогч улс болохоор бодлого, төлөвлөлтөө хийгээд явж байна.

“Клин Энержи Ази” компанийн хувьд байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хувьд ямар арга хэмжээ авч ажилладаг вэ?

Э.ОРЧЛОН: Мэдээж аливаа бүтээн байгуулалтыг барьж байгуулахад бидэнд ажилчдын эрүүл, аюулгүй байдал нөгөө талаас байгаль орчны аюулгүй байдал нэн тэргүүний асуудал байдаг. Манай аль ч станц нэг ч хүний бэртэл, гэмтэлгүйгээр үйл ажиллагаа явуулж, бүтээн байгуулалт хийсэн нь багаараа маш их бахархдаг зүйлийн нэг юм. Одоо хүртэл аюулгүй байдлын хувьд голчлон анхаарч ажиллаж байна. Манай орны бусад улсаас ялгарах давуу тал нь

говьд салхины нөөц, хурд өндөр байдаг ба тэнд салхин парк барьж байгуулъя гэхэд бусад салбартайгаа харшлах зүйл байдаггүй үүнд газар тариалан, мал аж ахуй, мөн хот суурин газар болох боломж ховор байдаг. Үүний бас нэг давуу тал нь говь нутагт салхин станц байгуулах нь усны маш их усны хэмнэлт болдог. Нүүрсэн станцын хувьд асар их хэмжээний ус ашиглагддаг. Бусад орны жишгээс харахад бусад салбаруудтайгаа харшлаад салхин станц барьж байгуулах боломж ховор байдаг.

Сэргээгдэх эрчим хүчний салбар манайд хэр хөгжих боломжтой зах зээл гэж харж байна вэ?

Э.ОРЧЛОН: Сэргээгдэх эрчим хүчний боломж гэж юу вэ гэхээр нэг талдаа хэрэглээ байна уу гэдэг асуудал юм. Манай улсын хувьд бие даасан бүрэн систем болж хөгжөөгүй байгаа бөгөөд дээрх дурдсан хоёр хөршөөс импортлох байгаа нь хэрэглээ байна уу гэвэл асар их байна. Дотоодын энэ хэрэгцээг нэг бол уламжлалт нүүрсний цахилгаан станцаар барина нөгөө талаар сэргээгдэх эрчим хүчний цахилгаан станцаар шийдвэрлэх боломж байна.

Дэлхийн томоохон орнуудын сүүлийн чиг хандлагаар бол нүүрсний цахилгаан станц дээр хөрөнгө оруулалт, санхүүжилт босгоно гэдэг нь их асуудалтай болж байна. Ийм учраас бид дотоодын асуудлаа сэргээгдэх эрчим хүчээр шийдэхээс өөр аргагүй болж байна. Нөгөө талаас мөн хөрш орнууд 2030 он гэхэд дийлэнх машины хэрэглээ цахилгаанжиж, хөдөлгүүр нь хосолсон хэлбэрээр ажиллахаар байгаа нь түлш, дизелийн хэмжээ төдий чинээ буурч, цахилгааны хэмжээ өсөх болно.

Мөн дата асар хурдацтай өсөж байна үүний жишээ болох хиймэл оюун ухаан, machine learning, 5G гэх мэт бүгдээрээ датан дээр суурьлаж байна. Дата гэдэг нь өөрөө эрчим хүч, цахилгаан гэсэн үг энэ их хязгааргүй хэрэглээг бид уламжлалт байдлаар шийдвэл нөөц шавхагддаг учраас хязгаарлагдмал байна. Үүнийг шавхагдашгүй нөөцөөр шийдэх зөв арга нь нар, салхины эрчим хүчээр, байгальд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүйгээр хангах боломжтой. Түрүүн дурдсаны дагуу БНХАУ, БНСУ, Япон орнууд арван жилийн дараа гэхэд ихээхэн хэмжээний цахилгаан шаардлагатай болох тул бидэнд экспортлох боломж, зах зээл байна. Бидний хувьд Монгол Улсыг сэргээгдэх эрчим хүч экспортлогч орон болгох зорилтын дагуу ажиллаад явж байна.

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт босгох, төсөл хэрэгжүүлэхэд төрөөс ямар дэмжлэг, татаас үзүүлж байна вэ?

Л.ЖАМБАА: 2019 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон ба үүнд нээлттэй тендерээр сонгон шалгаруулалт явуулах болсон өмнө нь

жишээ дурдаж хэлэхэд хөрөнгө оруулагч өөрөө газраа олж авч, эзэмших, суурь судалгаануудаа хийх, төслөө хөгжүүлэх, төрийн байгууллагуудтай уулзах гэх мэт маш их цаг хугацаа алдаж эрсдэлийг өөрөө даагаад явдаг байсан бол одоо төрөөс шаардлагатай байгаа суурь судалгааг хийж, хаана ямар байршилд, ямар хүчин чадалтай эрчим хүч үйлдвэрлэх гээд бүх зүйлийг тодорхой нарийвчлан гаргаж өгөөд төрөөс газрыг нь бэлдээд, хаана ямар холболт хийх талаар мөн ямар гэрээ, хэлэлцээр, нөхцөлийг нь тодорхой бэлэн болгоод тендерийг зарлана гэсэн үг.

Энэ нэмэлт, өөрчлөлт хийгдсэнээр хөрөнгө оруулагч хөрөнгө мөнгө босгох, компани байгуулах, бүтээн байгуулалт хийх, үйл ажиллагааг тогтвортой аваад явах тал дээр анхаарал хандуулаад явах ба төрийн зүгээс шаардлагатай зүйлийг холбогдох мэргэжлийн байгууллагууд нь хариуцаад явах болно. Иймд хөрөнгө оруулалт хийгдсэн төслийн хувьд зардал болон эрсдэлийг бууруулна. Урьд өмнө нь хэрэгжиж байсан төслүүд дээр төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс хийж, хариуцах ажил нь хэтэрхий их, цаг хугацаа авдаг байсан, тэр хэмжээгээр олон эрсдэлүүд өндөр байж зардал нэмэгддэг байсан. Шинэ хуулийн зохицуулалтаас дээрх эрсдэлүүдийг бууруулж, төслийн зардлыг бууруулах боломжтой болсон. Өөр нэг дэмжлэг гэвэл сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийг гаалийн татвар, нэмүү өртгийн албан татвараас чөлөөлөгдсөн байдаг, энэ мэтчилэн хөрөнгө оруулалтыг орчныг сайжруулсаар байна.

Өөрийн үнэт цагаа бидэнд зориулан сонирхолтой яриа өгсөн хоёр зочиндоо маш их Баярлалаа, Та бүхний ажилд амжилт хүсье.




Ярилцлага хийж бэлтгэсэн
ХӨБТХ-ийн мэргэжилтэн

С.БЭРЦЭЦЭГ

БИД ТАНЫ ХУУЛЬ ЁСНЫ ЭРХ, АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛНА

Монгол Улс болон Япон улс нь 2001 онд хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээр, 2015 онд хөрөнгө оруулалтын нөхцөлийг багтаасан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг тус тус байгуулж байжээ. Ингэснээр Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь 2 улсын хоорондын хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах үндсэн баримт бичиг болсон.

Монгол Улсын хувьд Ерөнхий сайдын дэргэд “Хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл”-ийг байгуулж буй бөгөөд Зөвлөл нь (1) хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж, тэдний гомдлыг олон улсын шүүх, арбитрын маргаан болохоос нь өмнө зөвшилцлийн замаар шийдвэрлэх, (2) Судалгаанд суурилсан гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын зөвлөмж, стратегийг гаргаж, Ерөнхий сайд, Засгийн газарт зөвлөмж өгөх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.



Зөвлөлийн ажлын алба болох Үндэсний хөгжлийн газар нь Дэлхийн банк группийн Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран “Хөрөнгө оруулагчаас гаргасан гомдлыг цахим хэлбэрээр бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих систем”-ийг хөгжүүлж, 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдөр ашиглалтад оруулсан.

Тус систем нь хөрөнгө оруулагчдын гомдлыг төрийн байгууллагуудын олон талын оролцоотойгоор шийдвэрлэх ба хөрөнгө оруулагчдад өөрийн гомдлын шийдвэрлэлтийн явцыг цахимаар хянах боломжийг олгосон. Зөвлөл болон системийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.ipc.gov.mn цахим хаягаас хүлээн авна уу.

INVEST IN MONGOLIA

February Newsletter



April Newsletter



March Newsletter



-  Засгийн газрын 2-р байр, Нэгдсэн Үндэстний Гудамж, Улаанбаатар 15160
-  www.nda.gov.mn
-  [/investmongolgov](https://www.facebook.com/investmongolgov)
-  [/ndagovMN](https://twitter.com/ndagovMN)
-  info@nda.gov.mn
-  976-51-261589, 7777 8787

investmongolia.com



Empowering The Economic Development Of Mongolia